

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ БА ХАРИУЦЛАГА

АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийг тэгш, хүртээмжтэй хуваарилах, улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үзэл санаа тусгалаа олсон билээ.

Энэ үзэл санааны хүрээнд төрийн өмчит компанийн (цаашид “ТӨК”) засаглалын ил тод байдал, сахилга бат, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх асуудал чухлаар тавигдах болсон ба улмаар холбогдох хууль тогтоомжийн шинэчлэл явагдаж байгаа билээ. Тухайлбал, Монгол Улсын УИХ-аас батлагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “...төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх”¹ гэсэн бодлогыг тусгасны зэрэгцээ Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан өргүүлэн мэдүүлэхээр заажээ.²

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, түүнийг сайжруулахад компанийн удирдлага буюу төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн тогтолцоо, чиг үүргийг бэхжүүлэх, түүний

эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Компанийн засаглалын хүрээнд ТУЗ-ийн тогтолцоо нь түүний бүтэц бүрэлдэхүүн, томилгоо зэрэг хэд хэдэн элементээс бүрдэх бөгөөд тэр дундаа ТУЗ-ийн бүрэн эрх, хүлээх үүрэг, хариуцлагын тогтолцоо нь ТУЗ-ийг бэхжүүлэхэд хамгийн чухал нөлөөтэй.

Манай улсын хувьд ТУЗ-ийн үйл ажиллагаа нь улс төрөөс хараат байдаг, ТУЗ-ийн гишүүнээр мэргэжлийн бус этгээд, захиргааны албан хаагчийг томилдог зэргээс шалтгаалан ТУЗ-ийн бүрэн эрх, үүрэг хариуцлагын тогтолцоо хангалттай бэхжээгүй байна.

Мөн Засгийн газар, салбарын яам, төрийн зохицуулагч байгууллага тус тусдаа удирдамж, чиглэл өгөх байдлаар ТӨК-ийн үйл ажиллагаанд оролцох, тэр нь зарим тохиолдолд хуулиар олгосон эрх хэмжээнээс хэтрэх явдал гардаг. Улмаар хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгч төрийн байгууллагууд хувьцаа эзэмшигчийн хувьд эдлэх өмчийн эрхээ төрийн зохицуулах чиг үүрэг буюу бодлого, төлөвлөлтөөр хангах үүрэгтэй холих алдаа түгээмэл байна.

Энэхүү судалгааны хүрээнд ТӨК-ийн ТУЗ-ийн

1 Монгол Улсын Их Хурал, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2020.08.28 №24 тогтоол 4.4.10.

2 Монгол Улсын Их Хурал, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, 2021.01.22 №12 тогтоол 1.8.52.



М.ТҮВШИНЖАРГАЛ
(Ph. D Erciyes Üniversitesi /Turkey)



А.БОДЬБИЛЭГ
(LL. M. Nagoya University)

бүрэн эрх буюу хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээ болон ТУЗ-ийн эрх мэдлийн хуваарилалтын зарчим, эрх зүйн орчин, мөн ТУЗ-ийн гишүүнд

хариуцлага хүлээлгэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг судлахыг зорьсон болно.

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН УДИРДЛАГА: ЭРХ МЭДЛИЙН ХУВААРИЛАЛТ

Төрийн өмчит компанийн эрх мэдлийн хуваарилалтын нөхцөл байдал

ТӨК-ийн засаглал сул байгаа нь компанийн засаглалыг хариуцан ажиллах ёстой ТУЗ-ийн институци өөрийн бүрэн эрхээ бие даасан, хараат бус байдлаар хэрэгжүүлж чадахгүй байгаатай салшгүй холбоотой. ТӨК-ийн хувьцаа эзэмшигч болох төр хувьцаа эзэмшигчийн хувиар эдлэх эрх хэмжээгээ хэтрүүлж компанийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад идэвхтэй оролцсоноор ТУЗ-ийн бие даасан байдлыг алдагдуулах, компанийн засаглалыг сулруулах зэрэг сөрөг үр дагавар бий болгож байна. Энэ нь хувьцаа эзэмшигч болох төр ТӨК-д ямар эрх хэмжээг эдлэх вэ, нөгөөтээгүүр ТӨК-ийн ТУЗ ямар эрх хэмжээг эдлэх вэ хэмээх бодлогын түвшний асуудлыг зайлшгүй судлах хэрэгцээ шаардлага үүсгэж байна.

Компанийн эрх зүй болон компанийн засаглалын орчин үеийн хандлагуудын үүднээс авч үзвэл, хувьцаа эзэмшигч компанийн үйл ажиллагаа, шийдвэрт идэвхтэй оролцох нь тийм ч зохистой биш бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг гагцхүү компанийн суурь асуудлуудын хүрээнд хязгаарлаж өгөхийг зөвлөдөг.³

Манай улсын хувьд ч хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн эрх мэдлийг хууль тогтоомжийн хүрээнд хуваарилахдаа уг зарчмыг баримталсан нь компанийн засаглалын харилцааны суурийг бүрдүүлэх Компанийн тухай хуулиас тод харагдана.⁴ ТӨК-иуд ч мөн адил дээрх зарчмыг баримталж хувьцаа эзэмшигч болох төр болон ТУЗ-ийн эрх мэдлийг хуваарилан хэрэгжүүлэх ёстой боловч бодит байдалд эрх мэдэл

хуваарилалтын дээрх зарчим алдагдах тохиолдол цөөнгүй бий.

Тодруулбал, ТУЗ нь компанийн үндсэн чиглэл ба бодлого, стратегийг тогтоох, компанийн удирдлага, хяналтыг бие даан хэрэгжүүлэх бүрэн эрхтэй боловч хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн байгууллагууд ТУЗ-ийн энэхүү бүрэн эрхийг давхар хэрэгжүүлдэг болохыг холбогдох судалгаа болон тайлангууд цохон тэмдэглэсээр иржээ⁵. Компанийн засаглалын үнэлгээний хүрээнд ч ТӨК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагаа сул, доогуур үнэлэгдсээр ирсэн байна.⁶ Түүнчлэн компанийг удирдлагаар хангах, хяналт хэрэгжүүлэх болон ТУЗ-ийн бүрэн эрхийн цөм болсон гүйцэтгэх удирдлагыг сонгон томилох бүрэн эрхэд ч төрөөс хувьцаа эзэмшигчийн нэрээр нөлөөлж, улс төрийн нөлөөлөл болон удирдамжаар дамжуулан гүйцэтгэх удирдлагыг томилох явдал цөөнгүй гардаг.⁷

Эрх мэдлийн хуваарилалтын зарчим алдагдах болсон үндсэн шалтгаан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (цаашид “ТБОНӨТХ”)–иас эхтэй. Өөрөөр хэлбэл, тус хуульд төрийн өмчийн удирдлагын эрхийг компанийн удирдлага, хяналтын эрх үүрэгтэй хольсон, мөн ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллагын бүрэн эрхэд олгосон байдал ажиглагддаг. Тухайлбал:

Нэг. УИХ, Засгийн газар болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллага

3 А.Сahn & David C.Donald, Comparative Company Law 468-482, Cambridge Uni. Pre. (2010).

4 Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл “Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх” гэж, КтХ-ийн 76 дугаар зүйл “Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх” гэж Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг тус тус хуульчилсан. Дэлгэрэнгүйг Хүснэгт 1 болон Хүснэгт 2-оос үзнэ үү.

5 Г.Давааням, М.Түвшинжаргал, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөл: Олон Улсын Туршлага ба Монгол Улс Уул уурхайн салбарын жишээн дээр, Нээлттэй Нийгэм Форум, 92 дах тал, 2022; Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн танилцуулга-2020, Дэд ажлын хэсгийн тайлан, 23 дах тал, 58 дах тал; Т.Цэнд-Аюуш, “ТӨБЗГ-ын ажилд Засгийн газар, яамдын амбич орж хяналтыг сулруулж, хулгай гарах нөхцөлийг бүрдүүлсэн” https://ikon.mn/n/2vprg?fbclid=IwAR0uDCt_eBfx0qHrJckfHyOHKKY-MNffimK6U6XxONiyUlttrwj_izMFd08 (Сүүлд үзсэн: 2023.08.01);

6 Д.Байлхүү, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын засаглалын үнэлгээ, Нээлттэй Нийгэм Форум, 21 тал (2014); Д.Байлхүү, Төрийн өмчит эрчим хүчний компаниудын засаглалын үнэлгээ, Нээлттэй Нийгэм Форум, 21 тал (2014).

7 Г.Давааням, М.Түвшинжаргал, өмнөх эшлэл 5, 92 тал.

нь ТӨК-ийн эд хөрөнгийг захиран зарцуулах эрхүүдийг эдлэх⁸ бөгөөд ТӨК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь эд хөрөнгийг захиран зарцуулах тухайлсан эрхгүй гэж хэлж болно.⁹ Компанийн удирдлагын хувьд ТБОНӨТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.3-т зааснаар “төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт олгосон байдгаас гадна ТБОНӨТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1-ийн дагуу “Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулах” эрх хэмжээг яам, тусгай газарт олгосон байна. Энэ нь ТУЗ-ийн бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэх ёстой асуудлыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллага шийдвэрлэх хууль зүйн үр дагаврыг бий болгожээ.

Хоёр. ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.6-д зүйлд хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллах үүргийг ТУЗ-д

Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх

Манай улсад ТӨК-ийн өмчийн удирдлага болон хувьцаа эзэмшигчийн эрхийн нэгдсэн бодлого тодорхойгүй явж ирснээс ТӨК-д хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээ бүдгэрч,

хүлээлгэсэн байдаг нь ТУЗ-ийн гишүүний хараат бус байдалд халдах боломжийг бий болгожээ. Улмаар төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын¹⁰ 2.1.4-т хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид “энэ журмын 2.1.3-т заасан этгээдээр дамжуулан төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, тухайн компанийн ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар санал оруулах, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчээс чиглэл авах” үүргийг тусгаж өгсөн нь ТУЗ-ийн бүрэн эрхэд шууд халдах хууль зүйн боломжийг нээж байна. Үүгээр зогсохгүй тус журмын 2.2-оор ТУЗ-ийн гишүүнд бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой өгөх удирдамжийн чиглэлүүдийг тогтоожээ.¹¹

Үүнээс үзвэл ТӨК-ийн ТУЗ өөрийн бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэхэд эрх зүйн хувьд тодорхой саад тулгардаг төдийгүй хувьцаа эзэмшигч болох төр өөрийн хувьцаа эзэмшигчийн эрхээс хэтэрсэн эрх хэмжээг эдлэхээр байгаа нь ТӨК-ийн эрх мэдлийн хуваарилалтын өнөөгийн дүр зургийг харуулж байна. Улмаар хувьцаа эзэмшигч болох төр компанийн үйл ажиллагаа, гаргах шийдвэрт оролцсоноор ТӨК-д улс төрийн зүй бус нөлөөлөл үүсэх бололцоог бүрдүүлжээ.

хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх байгууллагуудын уялдаа холбоо алдагдсанаар зогсохгүй зарим тохиолдолд хувьцаа эзэмшигч нь эрх хэмжээгээ хэтрүүлэх үзэгдэл гарсаар иржээ.¹²

8 ТБОНӨТХ-д төрийн өмчийн удирдлагын тухайд 8 дугаар зүйлд УИХ, 9 дүгээр зүйлд Засгийн газар, 11 дүгээр зүйлд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тус тус хуульчилсан байдаг. Жишээ нь ТБОНӨТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэгт зааснаар “төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах” бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт олгосон байдаг.

9 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн танилцуулга-2020, өмнөх эшлэл 5, 21 тал.

10 Засгийн газрын тогтоол 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралт, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”.

11 2.2.Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч доор дурдсан чиглэлээр энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан этгээдэд удирдамж өгнө:

- 2.2.1.компанийн тухайн жилийн бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг батлах;
- 2.2.2.компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох;
- 2.2.3.компанийн тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүү, аудитын тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;
- 2.2.4.ногдол ашгийн хэмжээг тогтоох, нэмэгдүүлэх;
- 2.2.5.бизнесийн тодорхой төсөл, томоохон хөрөнгө оруулалтын арга хэмжээ санхүүжүүлэх, хэрэгжүүлэх;
- 2.2.6.зээл авах, хувьцаа, үнэт цаас гаргахтай холбогдсон шийдвэр гаргах;
- 2.2.7.их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 2.2.8.компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг хэмнэх, эрсдэлийг бууруулах, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- 2.2.9.компанийн дүрэмд тухайлан заасан бусад

12 Үүнийг ТБОНӨТХ-д оруулсан 2014 оны нэмэлт өөрчлөлтөөс харах боломжтой. Тухайлбал, Засгийн газар төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг тогтоох агуулга бүхий зохицуулалт тус хуульд тусгагдсан нь төрийн өмчийн удирдлагын нэгдмэл тогтолцоог сулруулсан байх бөгөөд үүнтэй

Үүнд хэд хэдэн нөхцөл нөлөөлжээ.

- Төрийн өмчийн удирдлагын эрхийг хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхээс ялгахгүй байгаа нөхцөл байдал

Төр компанийн хувьцааг эзэмшсэнээр гагцхүү хувьцаа эзэмшигчийн эрхийг олж авах учиртай хэдий ч үүнийг төр компанийг бүрэн өмчилж байгаа мэт ойлгох хандлага оршсоор иржээ. Мэдээж төр ард түмнийг төлөөлөн хувьцаа эзэмшиж байгаа гэдэг утгаараа онцлог байж болох хэдий ч энэ нь компанийн засаглалын суурь болсон хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн эрх мэдлийн хуваарилалтын зарчмыг үгүйсгэх ёсгүй юм. Иймд ТӨК-ийн хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн эрх мэдлийн хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэхэд юуны өмнө “төр компанийн хувьцааг эзэмшсэнийхээ хариуд гагцхүү хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээг олж авна” гэх зарчмыг хэвшүүлэх шаардлагатай юм.

Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4-т “Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, гүйцэтгэх удирдлагыг томилох, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон

харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж зааснаас үзвэл ТБОНӨТХ-иар зөвхөн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх үйл явц, журмыг зохицуулах ба харин хувьцаа эзэмшигчийн эрхийн агуулгыг Компанийн тухай хуулиар зохицуулахаар байна.¹³ Иймд Компанийн тухай хуульд тусгасан хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээ нь ТӨК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг тодорхойлох суурь болох учиртай.

- Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийн хамрах хүрээ

Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт хувьцаа эзэмшигчийн эдлэх үндсэн эрхийг тусгаж өгсөн ба үүнд саналын эрх, ногдол ашиг авах эрх болон үлдсэн эд хөрөнгөөс хувь хүртэх эрх багтана.¹⁴ Тиймээс ТӨК-ийн хувьцаа эзэмшигч ч мөн адил дээрх эрхийг л эдлэх бөгөөд эдгээрээс тодорхой асуудлаар хувь тэнцүүлэн санал өгөх эрх нь хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийн агуулгыг илтгэнэ. Улмаар ихэнх тохиолдолд ТӨК-д төрийн хувь эзэмшил өндөр байдаг тул ТӨК-ийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д тусгагдсан дараах асуудлуудыг шийдвэрлэх эрхтэй гэж дүгнэж болох юм (Хүснэгт 1). Харин Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2-т заасан бүрэн эрх нь ТУЗ байгуулаагүй компанийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх учраас ТӨК-д хамааралгүй юм.

холбоотойгоор төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг бүрхэг болж, татан буугдаж байжээ.

13 Мөн Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 болон 2.5 дахь хэсэг нь төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг Компанийн тухай хуулиар зохицуулах агуулгатай.

14 Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1. “Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

34.1.1. хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;

34.1.2. давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;

34.1.3. компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх”.

Хүснэгт 1. Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх

1. Компанийн суурь шинжтэй өөрчлөлт	
КтХ 62.1.1	компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
КтХ 62.1.2	нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах
КтХ 62.1.4	компанийн хэлбэрийг өөрчлөх
КтХ 62.1.5	компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох
2. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, чөлөөлөх	
КтХ 62.1.7	төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох
3. Санхүүгийн үйл ажиллагааны хяналт, тайлан	
КтХ 62.1.9	компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
КтХ 62.1.14	энэ хуулийн 96.4-т заасан тайлан
4. Хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг шууд хөндөх асуудал	
КтХ 62.1.3	компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох
КтХ 62.1.6	хувьцааг хуваах буюу нэгтгэх
КтХ 62.1.8	энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх
КтХ 62.1.12	энэ хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх
5. ТУЗ шийдвэрлэсэн тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсэх асуудал	
КтХ 62.1.10	төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах
КтХ 62.1.11	төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах
КтХ 62.1.13	компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох

Дээрх хүснэгтээс үзвэл хувьцаа эзэмшигч нь гагцхүү компанийн суурь шинжтэй асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй гэж дүгнэж болно. Үүнд компанийн удирдлага, үйл ажиллагааны асуудал багтахгүй ба хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн үйл ажиллагаа болон бүрэн эрхэд шууд оролцох эрхгүй болохыг анхаарах ёстой. Харин хувьцаа эзэмшигч нь компанийн удирдлагыг хариуцан ажиллах үүрэг бүхий ТУЗ-ийн гишүүнийг сонгож, түүгээр дамжуулан компанийг шууд бусаар засаглах нь орчин үеийн компанийн засаглалын гол загвар билээ.

- Хувьцаа эзэмшигчийн эрхийг өргөжүүлэх асуудал

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15-д “төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал” гэж, мөн 62.1.16-д “энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал” гэж заасан байдаг тул хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг ТУЗ-ийн саналаар эсхүл компанийн дүрмээр дамжуулан өргөжүүлэх боломжтой. Улмаар дээрх зохицуулалтын агуулгын дагуу ТУЗ-ийн бүрэн

эрхэд хамаарах асуудлыг хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхэд хамааруулах боломжтой юу гэх асуулт үүснэ. Жишээ нь: ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах “компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох” эсхүл “гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох” асуудлыг хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхэд хамааруулах боломжтой юу? ТӨК-ийн хувьд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг компанийн тухай хуульд зааснаас өөрөөр буюу тухайлбал ТБОНӨТХ, Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын хүрээнд өргөжүүлэн тогтоодог бөгөөд тэдгээр нь ерөөс үндэслэлтэй, хүчин төгөлдөр эсэх тухай асуудал юм. Уг асуултын хариулт нь тухайн компанийн хэлбэр, бүтэц, хувьцаа эзэмшигчийн онцлог шинж зэрэг олон хүчин зүйлээс хамаарах боловч хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг өргөжүүлэх нь компанийн сайн засаглалын үүднээс зохисгүй юм.¹⁵

Тодруулбал, ТУЗ-ийн бүрэн эрхийг хуульчилсан хууль тогтоомж нь заавал дагаж мөрдөх шинжтэй, гуравдагч этгээдэд ч нэгэн адил үйлчлэх үр дагавартай байдаг тул ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг бусад хууль тогтоомж эсхүл компанийн дүрмээр дамжуулан хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхэд хамааруулах боломжгүй гэх тайлбар хүчтэй байдаг.¹⁶ Учир нь ТУЗ нь өөрөө мэргэжлийн менежер гэдэг утгаараа ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах нарийн төвөгтэй асуудлуудын талаар үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлэх, асуудлыг компанийн эрх

ТУЗ-ийн бүрэн эрх

ТУЗ нь компанийг удирдлагаар ханган ажиллах ёстой компанийн засаглалын цөм институци юм. Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн гишүүдийг сонгодог хэдий ч ТУЗ нь зөвхөн хувьцаа эзэмшигчийн эрх ашгийн төлөө бус компанийн эрх ашгийн төлөө, компанийн бүхий л оролцогч талуудын ашиг сонирхлыг сахин хамгаалах үүргийг хүлээдэг.

Гэвч ТӨК-ийн хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн бүрэн эрхэд халдсаар ирсэн бөгөөд ТБОНӨТХ-д ТӨК-ийн ТУЗ-ийн бүрэн эрхийг бэхжүүлэхэд

ашгийн үүднээс дэнсэлж үзэх боломж нь хувьцаа эзэмшигчээс харьцангуй өндөр байдаг.

Тиймээс ТӨК-ийн хувьд ч нэгэн адил ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг ТБОНӨТХ эсхүл төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмаар дамжуулан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллагад хуваарилах нь оновчгүй юм. Ялангуяа ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.6-аар ТУЗ-д хувьцаа эзэмшигчийн зүгээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллах үүргийг оногдуулсан нь хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д зааснаас өргөжүүлснээс гадна төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын 2.1.4 болон 2.2 нь ТУЗ-ийн бүрэн эрхийг шууд хөнджээ. Түүнчлэн ТБОНӨТХ нь эд хөрөнгийн эрх хэмжээг гагцхүү хувьцаа эзэмшигчид хадгалснаар ТУЗ-ийн бүрэн эрхийг бүдгэрүүлсэн байна.

Иймд ТБОНӨТХ болон төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын дээрх зохицуулалтууд нь хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн эрх мэдлийн хуваарилалтын зарчмыг хөндсөн шинжтэй байгааг цохон дурдах нь зүйтэй байна.

Энэ бүхнээс дүгнэвэл ТӨК-ийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийн агуулга нь эрх мэдлийн хуваарилалтын зарчмын дагуу Компанийн тухай хуулийн 62.1-д заасан асуудлуудаар хязгаарлагдах учиртай. (Хүснэгт 1-ийг харна уу).

чиглэсэн зохицуулалт одоогоор байхгүй байна. Гэсэн хэдий ч ТБОНӨТХ эсхүл төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журамд тусгагдсан эсэхээс үл хамааран Компанийн тухай хууль ТУЗ-ийн бүрэн эрхийг баталгаажуулах суурь болж үйлчлэх учиртай.

ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д тусгагдсан дараах бүрэн эрхүүдийг бие даан, хараат бусаар хэрэгжүүлэх ёстой (Хүснэгт 2).

15 Lucian Bebchuk, The Case for Increasing Shareholder Power, 118(3) Harv. Law Rev. 833, 843-847 (2005).

16 Luca Enriques, Henry Hansmann & Reinier Kraakman, The Basic Governance Structure: The Interests of Shareholders as a Class, in THE ANATOMY OF CORPORATE LAW 94-97 (R. Kraakman et al. eds. 3rd ed. 2017).

Хүснэгт 2. ТУЗ-ийн бүрэн эрх¹⁷

ТУЗ-ийн бүрэн эрх

КтХ 76.1.1	компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох
КтХ 76.1.2	хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах
КтХ 76.1.3	хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх
КтХ 76.1.4	компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах
КтХ 76.1.5	компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах
КтХ 76.1.6	энэ хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох
КтХ 76.1.7	өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах
КтХ 76.1.8	компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох
КтХ 76.1.9	компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох
КтХ 76.1.10	аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох
КтХ 76.1.11	компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах
КтХ 76.1.12	компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох
КтХ 76.1.13	төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах
КтХ 76.1.14	компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах
КтХ 76.1.15	компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх
КтХ 76.1.16	энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох
КтХ 76.1.17	энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох
КтХ 76.1.18	энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал

ТУЗ нь компанийг удирдах, хяналт тавих бүрэн эрхийг эдлэх ба гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх замаар уг эрхээ хэрэгжүүлдэг. Энэ эрхээ хэрэгжүүлж чадахгүй бол ТУЗ-ийн компанийг удирдах болон хяналт тавих чиг үүрэг бодит байдал дээр алдагдаж улмаар хэлбэрийн

төдий институци болж хувирах хор уршигтай. Жишээ нь: Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал нь тус компанийн ТУЗ-аас үл хамааралтайгаар томилогдсоор ирсэн гэж дүгнэж болно (Хүснэгт 3).

¹⁷ Эдгээр бүрэн эрхүүдтэй холбоотойгоор ТУЗ-ийн хараат бус гишүүн болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь илүү тухайлсан бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжтой (Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.3 болон 81 дүгээр зүйл).

Хүснэгт 3. Эрдэнэс Монгол ХХК-ний гүйцэтгэх захирлыг томилсон байдал

Гүйцэтгэх захирал	Томилсон байдал	Хугацаа
1 Б.Бямбасайхан	Засгийн газрын тогтоол	2015.02.15-2016.09.29
2 Ц.Түмэнцогт	ТУЗ-ийн шийдвэр/удирдамж	2016.09.29-2018.05.17
3 П.Ганхүү	ТУЗ-ийн шийдвэр/удирдамж	2018.05.17-2020.10.12
4 Д.Хаянхярваа	ТУЗ-ийн шийдвэр/удирдамж	2020.10.12-2021.10
5 О.Хулан (гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч)	Засгийн газрын тогтоол	2021.10-2022.11.30
6 С.Наранцогт	Засгийн газрын тогтоол	2022.11.30-өнөөг хүртэл

Иймд ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох, чөлөөлөх бүрэн эрхийг зайлшгүй баталгаажуулж, улс төрөөс хараат бусаар

компанийн үйл ажиллагааг удирдан явуулах бололцоог бүрдүүлэх нь зүйтэй.

Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн эрх мэдлийн хуваарилалтын зарчим: Олон улсын сайн туршлага

ЭЗХАХБ нь 2015 онд Төрийн өмчит компанийн засаглалын удирдамжийг баталжээ. Тус удирдамжийн 2 болон 7 дугаар бүлэгт төр хувьцаа эзэмшигчийн хувьд компанийн засаглалд ямар үүрэг гүйцэтгэх (the state's role as an owner), нөгөөтээгүүр ТӨК-ийн ТУЗ нь ямар эрх хэмжээг

бие даан хэрэгжүүлэх (the responsibilities of the boards of state-owned enterprises) талаар тодорхой зөвлөмжүүд гаргасан байдаг. Энэхүү зөвлөмжүүдийг доорх байдлаар хүснэгтлэн авч үзэх ба холбогдох дэлгэрэнгүй тайлбарыг эшлэл болгон хавсаргав (Хүснэгт 4).

Хүснэгт 4. ЭЗХАХБ-ийн ТӨК-ийн засаглалын удирдамж 2015

Өмчлөгч (Хувьцаа эзэмшигч) болох төрийн эрх хэмжээ	ТУЗ-ийн эрх хэмжээ
1) Төр нь ТӨК-д тодорхой төлөвлөгөөний хүрээнд бие даан ажиллах бүрэн эрх олгож, ТӨК-ийн удирдлагад хөндлөнгөөс оролцохоос зайлсхийх ёстой. ¹⁸	1) ТӨК-ийн ТУЗ нь компанийг стратеги удирдлагаар хангах болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, ур чадвар, хараат бус байдлыг бүрдүүлэх ёстой.
2) Төр нь ТӨК-ийн ТУЗ өөрийн бүрэн эрх, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд саад учруулах ёсгүй бөгөөд ТУЗ-ийн хараат бус байдлыг хүндэтгэх ёстой. ¹⁹	2) ТУЗ нь тодорхой даалгавар (mandate)-ын дагуу ажиллах бөгөөд компанийн үйл ажиллагаанд эцсийн хариуцлага хүлээнэ. Түүний чиг үүргийг боломжтой бол компанийн тухай хуулиар нарийвчлан тодорхойлох нь зүйтэй. ТУЗ нь өмчлөгчийн өмнө тайлагнах үүрэг хүлээх бөгөөд компанийн эрх ашгийн төлөө чармайн ажиллаж, бүхий л хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах үүрэгтэй. ²⁰

18 Төр мэдээлэлтэй, идэвхтэй хувьцаа эзэмшигч байх хамгийн гол арга зам бол ойлгомжтой, уялдаа холбоо бүхий "Өмчлөлийн бодлогыг"-ийг батлан уг бодлогын хүрээнд ТӨК-ийн суурь зорилго, стратегийг тодорхойлох нь зохимжтой. Улмаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллагын бүрэн эрх нь суурь стратегийн асуудал эсхүл төрийн бодлогын хүрээнд байвал зохино. Төр компанийн үйл ажиллагаа, менежментийн шийдвэрт оролцох ёсгүй. Төр ямар салбарт, ямар төрлийн асуудлаар удирдамж өгөхөө тодорхойлж, нийтэд ил болгох ёстой.

19 Аливаа чиглэл, удирдамжийг шууд ТУЗ-д хүргүүлэх бус хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллагаараа дамжуулан уламжлах нь зүйтэй.

20 ТӨК-ийн ТУЗ-ийн үүрэг хариуцлага, эрх хэмжээ нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, өмчийн бодлогын баримт бичиг болон компанийн дүрэмд тусгагдсан байх ёстой. ТУЗ-ийн бүх гишүүд компанийн ашиг сонирхлын төлөө ажиллаж, бүх хувьцаа эзэмшигчдэд адил тэгш хандах хууль зүйн үүрэгтэй болохыг онцлон тэмдэглэх нь зүйтэй. ТУЗ-ийн хариуцлагыг хөхиүлэн дэмжих, үр дүнтэй ажиллагааг хангахад хувийн секторын шилдэг туршлагуудыг дагаж мөрдөх нь зүйтэй.

3) Төрийн зүгээс ТӨК-ийн үйл ажиллагаанд мэдээлэлтэй, идэвхтэй хувьцаа эзэмшигчийн хувиар оролцох нь зохистой. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхдээ компани тус бүрийн эрх зүйн хэлбэрт тохируулан үйл ажиллагаанд нь зөвхөн хуулийн хүрээнд оролцвол зохих ба ингэхдээ төрийн зүгээс дараах чиг үүрэгтэй оролцоно:

- Төлөөлөгчөөрөө дамжуулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, саналын эрхээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх
- Санхүүгийн зорилтууд, хөрөнгийн бүтэц болон эрсдэлийн үнэлгээний түвшинд тулгуурлан үйл ажиллагааны зорилгыг тодорхойлох, хэрэгжүүлэх, хяналт тавих.
- ТӨК-ийн урт болон дунд хугацааны зорилгыг хэрэгжүүлэхэд мэргэшсэн, ур чадвар бүхий ТУЗ бүрдүүлэх боломжийг хөхиүлэн дэмжих, үр ашигтай ажиллагааг дэмжих цалин урамшууллын нээлттэй систем бий болгох.²¹

4) Төр ТУЗ-д өөрийн үзэл санаа, шаардлагаа хууль ёсны механизмаар дамжуулан уламжлах шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн бие даасан, хараат бус байдлыг хамгийн ихээр хүндэтгэх шаардлагатай.

3) ТУЗ нь төрөөс тогтоосон даалгавар болон зорилгод үндэслэн компанийн стратегийг боловсруулах, гүйцэтгэх удирдлагад хяналт тавих чиг үүрэгтэй. Мөн гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх бүрэн эрхтэй. Түүнчлэн компанийн урт хугацааны бодлогод тулгуурлан гүйцэтгэх удирдлагын багийн цалин урамшууллыг тогтоох нь зүйтэй.²²

4) ТУЗ нь хөндлөнгийн байр сууринаас, хараат бусаар шийдвэр гаргана. Төрийн албан хаагчаас эхлээд ТУЗ-ийн бүх гишүүн тодорхой шалгуураар томилогдон, хуулийн өмнө адил хариуцлага хүлээнэ.

5) ТУЗ-ийн үйл ажиллагаанд улс төрийн оролцоог хязгаарлах механизм нэвтрүүлэхээс гадна ТУЗ-ийн гишүүн нь ажил үүргээ гүйцэтгэхдээ саад болох аливаа сонирхлын зөрчлөөс зайлсхийх шаардлагатай.

21 Улс төрийн оролцоо эсхүл хяналтгүй байдлаас зайлсхийхийн тулд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь хувьцаа эзэмшигчийн эрхээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд анхаарах нь чухал. Төр компанийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хэмжээний хувьцаа эзэмшиж байгаа тохиолдолд олонх хувьцаа эзэмшигчийн хувиар, харин цөөнх хувьцаа эзэмшигч байх тохиолдолд мэдээлэлтэй, идэвхтэй хувьцаа эзэмшигчийн хувиар эрх хэмжээгээ хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хувьцаа эзэмшигчийн суурь эрхэд 1) хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал өгөх, 2) компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол авах, 3) ТУЗ-ийн гишүүдийг томилох, чөлөөлөх, 4) их хэмжээний хэлцлийг батлах, 5) ногдол ашгийг хуваарилах, компанийг татан буулгах талаар санал өгөх зэрэг багтана. Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь эдгээр эрхээ ТӨК-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд саад бололгүйгээр бүрэн дүүрэн, хууль ёсны дагуу хэрэгжүүлэх шаардлагатай. ТӨК-ийн засаглалын үр нөлөөтэй болон найдвартай байдал нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч өөрийн эрхийг мэдээлэлтэйгээр хэрэгжүүлж чадах эсэхээс ихээхэн шалтгаална.

Төр нь компанийн засаглалд гүйцэтгэх үүргээ зөвхөн хувьцаа эзэмшигчийн хувьд эдлэх саналын эрхээрээ дамжуулан хэрэгжүүлбэл зохино. Тиймээс хувьцаа эзэмшигчийн хуралд төрийн саналын эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх тодорхой журмыг батлах нь чухал. Үүний тулд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийг томилж өгөх шаардлагатай. Ийнхүү томилогдсон этгээд нь саналын эрхээ хэрэгжүүлэхдээ бүрэн, найдвартай мэдээлэлд үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дамжуулан ТУЗ-д уламжлах нь зүйтэй.

22 ТУЗ нь өөрийн чиг үүргээ гүйцэтгэхдээ дараах бүрэн эрхүүдийг зайлшгүй хэрэгжүүлэх ёстой. 1) Компанийн ерөнхий зорилгын хүрээнд компанийн стратегийг батлах, хяналт тавих, 2) Аливаа төлөвлөгөө, үүрэг даалгаврын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг бэлтгэх, гол эрсдэлүүдийг тооцоолох, 3) Үр дүнтэй эрсдэлийн удирдлагыг боловсруулж, санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлтэй холбоотой бодлого, журмыг хөгжүүлэх, 4) ТӨК-ийн санхүүгийн тайланд ТӨК-ийн нөхцөл байдал болон эрсдэлийг бодитоор тусгасан эсэхийг баталгаажуулж, хяналт тавих, 5) Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж, хяналт тавих, 6) Гүйцэтгэх захирлын цалин урамшууллыг шийдвэрлэж, дараа дараагийн залгамж халааг бэлтгэх.

Гүйцэтгэх захирлыг томилж, чөлөөлөх нь ТУЗ-ийн хамгийн чухал бүрэн эрхийн нэг. Ийм эрхгүйгээр ТУЗ нь өөрийн хяналтын чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүйгээс гадна компанийн үйл ажиллагаа, гүйцэтгэлд хариуцлага хүлээх боломжгүй юм. Зарим тохиолдолд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр гүйцэтгэх захирлыг томилох боломжтой байж болох юм.

Зарим улс энэхүү сайн туршлагаас хазайдаг бөгөөд зарим тохиолдолд 100 хувь төр өмчилдөг компанийн гүйцэтгэх захирлыг төрөөс шууд томилдог жишээ бий. ТУЗ-ийн үр дүнтэй байдлыг хангахын тулд олон улсын сайн жишгийн дагуу гүйцэтгэх захирлыг төрөөс шууд томилохдоо дор хаяж ТУЗ-тэй зөвшилцдөг байх шаардлагатай.

Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн эрх мэдлийн хуваарилалтын зарчмыг бэхжүүлэх зарим улс орны туршлага

- Өмчлөлийн бодлого

Төрийн өмчийн удирдлага ба ТӨК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээний зааг ялгаа бүдгэрч, хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээ нэгдсэн бус, уялдаа холбоогүй болсноос үүдэн ТӨК-д хувьцаа эзэмшигч, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын эрх мэдлийн хуваарилалт алдагддаг. Иймд төрийн өмчийн удирдлагыг ТӨК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээнээс ялгах зорилгоор улс орнууд ТӨК-ийн өмчлөлийн нэгдсэн бодлогыг бий болгодог ба үүнийгээ тодорхой хууль тогтоомж эсхүл бодлогын баримт бичгээр баталгаажуулдаг. “ТӨК-ийн өмчлөлийн бодлого” (Ownership policy)-г батлах замаар хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн эрх мэдлийг хуваарилсан улс орнууд цөөнгүй бий.²³

- Финланд Улс

Финланд Улс Төрийн өмчит компанийн өмчлөл ба хувьцаа эзэмшигчийн эрхийн тухай хууль²⁴-иар дамжуулан ТӨК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг нэгдсэн үзэл баримтлалын хүрээнд маш ойлгомжтой тодорхойлсноор зогсохгүй төрийн өмчийн удирдлагыг ТӨК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхээс бүрэн дүүрэн зааглаж чаджээ. Тодруулбал, тус хуулийн 2 дугаар зүйлд “Төрийн өмчийн удирдлага гэдэг нь төрөөс компанийн удирдлага болон үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчийн хувиар хуралд оролцож саналын эрхээ хэрэгжүүлэх болон бусад арга замаар дамжуулан хувь нэмрээ оруулахыг хэлнэ” гэж тусгасан байдаг.²⁵

Тус хуулийн 3, 4 болон 5 дугаар зүйлд зааснаар парламент болон Засгийн газрын ТӨК-д хэрэгжүүлж болох эрх хэмжээ нь хөрөнгө оруулалт болон өөрийн мэдлийн хувьцааг захиран зарцуулах эрхээр хязгаарлагдах бөгөөд

компанийн санхүүгийн болон удирдлагын аливаа асуудалд оролцох эрхгүй байна.²⁶

- Норвеги Улс

Норвеги Улсын “ТӨК-ийн өмчлөлийн бодлого”²⁷-ийн 8 дугаар бүлэгт төрийн өмчит компанитай холбоотой төрийн чиг үүргийг 1) зохицуулах буюу rules formulator, 2) нийтийн хяналт хэрэгжүүлэх буюу public supervisor authority, 3) төрийн эзэмшлийн хувьцаа болон өмчийг удирдах буюу manager of the state’s shares and other property хэмээн тодорхойлжээ. Түүнчлэн тус бодлогын 9.2.1-д “Компанийн удирдлага нь ТУЗ болон гүйцэтгэх захирлаас бүрдэнэ. ТӨК үүсгэн байгуулах аливаа тохиолдолд хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн эрх мэдлийн маш тодорхой хуваарилалтыг чанд баримтлах ёстой” гэж заасан байдаг. Төр нь өмчлөгч болохынхоо хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлаар дамжуулан хуулийн хүрээнд өөрийн ашиг сонирхлыг хамгаална²⁸ гэж тусгасан байдаг.

- Швед Улс

Швед Улсын “ТӨК-ийн өмчлөлийн бодлого”²⁹-ийн 2.1-д төр компанийн удирдлага, үйл ажиллагаанд гагцхүү хувьцаа эзэмшигчийн хувиар буюу хувьцааг захиран зарцуулах, хөрөнгө оруулах бүрэн эрхийнхээ хүрээнд оролцохыг цохон тэмдэглэж, 2.4-д ТӨК-иудад хувийн эрх зүйн секторын бүх хууль тогтоомж нэгэн адил үйлчлэхийг тунхаглажээ. Мөн хувьцаа эзэмшигчийн зүгээс ТӨК-д өгөх аливаа удирдамжийг гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар дамжуулахыг үүрэг болгож, тухайн удирдамж нь хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээний хүрээнд албан ёсоор гарсан, мөн тодорхой байх шаардлагыг тусгаж өгсөн³⁰ нь анхаарал татаж байна.

23 Улс орнуудын “Төрийн өмчлөлийн бодлого”-ын талаарх дэлгэрэнгүйг OECD, Organising the state ownership function: Implementing the OECD Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises, 55-68 (2020)-оос үзнэ үү.

24 Act on state company ownership and ownership control, 21.12.2007/n.1368,

25 Section 2. “The state’s ownership control refers to the use of the state’s right to vote in general meetings and other measures by which the state, as a shareholder, contributes to the management and operating principles of the companies.”

26 The ministry responsible for owner guidance processes and resolves matters concerning: 1) appointing government representatives to general meetings and giving them instructions; 2) exercise of rights belonging to the state as a shareholder; 3) other ownership control of the companies.

27 Ministry of Trade and Industry, The Government Ownership Policy, Oslo (2008).

28 9.2.1 Management of the company “The management of a company consists of the board of directors and the general manager. As a form of incorporation, the limited company, and other forms of incorporation used for the state’s enterprises, is based on a clear division of roles between the shareholders and the company’s management. Within the general and specific limits stipulated by the Storting for the enterprise, the state as owner furthers its interests through the general meeting/ enterprise general meeting.”

29 Government offices of Sweden, State Ownership Policy and principles for state-owned enterprises, Stockholm (2020).

30 4.2 Ownership instructions “The owner gives instructions to the enterprise’s board of directors in owner instructions. In state-

- Эстони Улс

Эстони Улсад сайдын зүгээс ТӨК-ийн ТУЗ-д хандсан шууд удирдамж өгдөг байсан практикийг халж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар дамжуулан албан ёсоор санал өгөх шаардлагыг хуульчилжээ.³¹

Дээрх жишгээс үзвэл, төрийн өмчийн удирдлагын эрх болон хувьцаа эзэмшигчийн эрхийг зааглаж,

ТУЗ-ийн бүрэн эрхийг бэхжүүлэх олон улсын сайн туршлага

ТУЗ нь компанийг стратегийн удирдлагаар хангах, хяналт тавих бүрэн эрхтэй. ТӨК-ийн хувьд ТУЗ-ийн энэ эрхийг тодорхой тусгаж өгөх нь ТУЗ-ийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх суурь алхам юм. Ялангуяа ТӨК-ийн өмчлөлийн нэгдсэн бодлогогүй буюу хувьцааны эзэмшлийн төвлөрсөн бус загвартай улс орнуудад ТӨК-ийн ТУЗ-ийн бүрэн эрх тодорхойгүй, улмаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллага бодит байдал дээр ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх хандлагатай байдаг байна.³³ Ийм учраас ЭЗХАБ-ын зөвлөмж нь ТУЗ-ийн бүрэн эрхийг компанийн тухай хуульд тусгаж өгөхийг зөвлөсөн байдаг. ТУЗ-ийн бүрэн эрхэд төрөл бүрийн эрх хамаарах боловч олон улсын сайн жишгийн дагуу ТӨК-ийн ТУЗ-д дараах хоёр эрхийг заавал олгож, бодитоор хэрэгжүүлэх нь хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн эрх мэдлийн хуваарилалтын зарчмыг бүрдүүлэх суурь болдог.³⁴

1. Компанийг стратегийн удирдлагаар хангаж, чухал шийдвэрийг гаргах;
2. Гүйцэтгэх удирдлагад хяналт тавьж, гүйцэтгэх захирлыг томилох бүрэн эрх болно.

Эдгээр нь ТӨК-ийн ТУЗ-ын хувьд хамгийн өндөр ач холбогдолтой, суурь эрх юм.

- *Компанийг стратегийн удирдлагаар хангаж, чухал шийдвэрийг гаргах*

ТӨК-ийн ТУЗ-д хууль тогтоомжийн дагуу

төр нь ТӨК-д зөвхөн хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээг эдлэх суурь зарчмыг тогтоосон нь эрх мэдлийн хуваарилалтыг оновчтой тогтоох хамгийн чухал алхам гэж харагдаж байна. Үүнд ч ТӨК-ийн өмчлөлийн бодлогын гол цөм оршдог гэж үзэж болох юм.³²

компанийг удирдлагаар хангах бүрэн эрхийг олгодог боловч бодит байдал дээр ТУЗ түүнийг бие даан хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл тулгарах нь бий. Ихэнх тохиолдолд ТӨК-ийн зорилго, санхүү, үйл ажиллагааны чиглэлийг төрөөс тогтоож өгдөг нь үүний гол шалтгаан юм. Мөн төрийн аль нэг байгууллага хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн хувиар компанийн зарим чухал хэлцэл болон бизнесийн шийдвэрийг гаргах хууль ёсны бүрэн эрхтэй байдаг. Мэдээж хувьцаа эзэмшигчийн эрхийг хүлээн зөвшөөрөх шаардлагыг үгүйсгэхгүй ч хурдтай шийдвэр гаргах зайлшгүй шаардлага үүссэн үед хувьцаа эзэмшигчийн зөвшөөрөл нь ТУЗ-ийн үйл ажиллагаанд саад болж, ТУЗ-ийн бие даасан байдлыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлдэг.

Тиймээс ТУЗ-ийн мэргэшсэн байдал болон ТӨК-ийн засаглал сайжрахын хэрээр ТУЗ-ийн компанийг стратегийн удирдлагаар хангах бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, компанийн өдөр тутмын үйл ажиллагаа, бизнесийн хэлцэлд төрөөс зөвшөөрөл авдгийг халах шаардлагатай юм.³⁵

- *Гүйцэтгэх захирлыг томилох, гүйцэтгэх удирдлагыг хянах*

Мэргэжлийн бөгөөд ур чадвартай гүйцэтгэх удирдлагыг томилох нь ТӨК-ийн засаглал хийгээд гүйцэтгэлийг сайжруулах хамгийн чухал алхам билээ. Олон улсын сайн жишигт ч

owned enterprises, owner instructions are mainly used when an enterprise has a specifically adopted public policy assignment; receives budget appropriations; or is being restructured and also in the context of deregulation or other similar material changes. The content of owner instructions has to be relevant, specific and clear and is formalised through decisions at general meetings. Where an assignment is given in owner instructions, the instructions have to state clearly how the assignment will be financed, reported and tracked."

31 World Bank, Corporate Governance of State-Owned Enterprise: A Toolkit, 74 (2014).

32 Id. at 47

33 OECD, Professionalising Boards of Directors of State-Owned Enterprises: Stocktaking of National Practices, 9 (2018).

34 Үүнтэй холбоотой улс орнуудын хийсэн арга хэмжээнүүдийн талаарх дэлгэрэнгүйг OECD, supra note 23, at 13 болон OECD, State-Owned Enterprise Governance Reform: An Inventory of Recent Change, 24, 50 (2011)-ээс үзнэ үү.

35 Олон улсын дараах сайн жишгийг дурдаж болно. Жишээ нь: Энэтхэг Улсад гүйцэтгэлийн өндөр үнэлгээтэй зарим томоохон компанийн хувьд ТУЗ-ийн бүрэн эрхийг дэмжихийн тулд тодорхой үнийн дүнгийн босгыг тогтоох замаар чухал шийдвэрийг бие даан гаргах ТУЗ-ийн эрхийг баталгаажуулдаг. Хятад Улс "ТӨК-ийн засаглалыг сайжруулах зөвлөмж" баталж, ТӨК-ийг стратегийн удирдлагаар хангах, чухал шийдвэр гаргах бүрэн эрхийг гагцхүү ТУЗ бие даан хэрэгжүүлэхийг тунхаглаж өгчээ. Египет Улсын 2006 онд баталсан "ТӨК-ийн засаглалыг дэмжих зөвлөмж"-д ч ТӨК-ийг стратегийн удирдлагаар хангаж, түүнд хяналт тавих бүрэн эрхийг ТУЗ хэрэгжүүлэхийг цохон тэмдэглэжээ.

гүйцэтгэх удирдлагыг томилох эрхийг ТУЗ-ийн хамгийн чухал бүрэн эрх гэж үздэг. Зарим улсад ТӨК-ийн гүйцэтгэх захирлыг төрөөс томилдог жишиг байдаг боловч энэ нь тогтолцооны дараах суурь асуудлуудыг бий болгодог. Нэгдүгээрт, гүйцэтгэх захирлыг төрөөс томилох нь ТУЗ-ийн хамгийн чухал бүрэн эрхэд халдсан явдал бөгөөд ТУЗ-ийн бусад эрх, чиг үүргийг бүдгэрүүлдэг. Хоёрдугаарт, гүйцэтгэх захирлын ТУЗ-ийн өмнө хүлээх хариуцлагыг сулруулж, компанийн үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн байгууллагын нөлөөллийг нэмэгдүүлдэг.

Тийм учраас олон улсын сайн жишгийн дагуу гүйцэтгэх захиралд хяналт тавих боломжийг бүрдүүлэхийн тулд түүнийг томилох, чөлөөлөх бүрэн эрхийг ТУЗ-д олгох нь зүйтэй гэж үздэг.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд тусгагдсан байдал

Энэ хэсэгт өмнө авч үзсэн эрх мэдлийн хуваарилалтын зарчим болон ТӨК-ийн ТУЗ-ийн эрх хэмжээтэй холбоотой сүүлийн үед гарсан зарим шийдвэр, арга хэмжээнд тулгуурлан

Ингэснээр ТӨК-ийн удирдлага, шийдвэрт төрийн оролцоо багасах сайн талтай.

Ихэнх хөгжингүй улсад ТӨК-ийн ТУЗ гүйцэтгэх захирлыг томилох бүрэн эрхтэйг тодорхой хуульчилсан байдаг. ТУЗ-ийн энэхүү бүрэн эрхийг бодитой хэрэгжүүлэхийн тулд ТУЗ болон хувьцаа эзэмшигчийн зөвшилцлийн үр дүнд гүйцэтгэх захирлыг томилох жишгийг баримталдаг улс байдаг ч гүйцэтгэх захирлыг томилох бүрэн эрхийг гагцхүү ТУЗ эдлэх ёстой гэсэн нийтлэг хандлага олон улсад давамгайлж байна.³⁶

ТУЗ-ийн хараат бус, мэргэшсэн байдал бэхжихийн хэрээр гүйцэтгэх захирлыг томилох бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж бүрдэх ба хувьцаа эзэмшигч болох төр гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар дамжуулан энэхүү шийдвэрт оролцох юм.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд шинжилгээ хийх болно (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Хуулийн төсөлд хийсэн шинжилгээ

1. Төрийн өмчийн удирдлагын эрхийг хувьцаа эзэмшигчийн эрхээс ялгах	
Тодорхой хэмжээнд нийцсэн	Хуулийн төслийн 5.3 дугаар зүйлд “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх Засгийн газрын болон орон нутгийн эрх хэмжээ нь хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын бүрэн эрхээс тусгаарлагдсан байх, компанийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн талаар гаргах аливаа шийдвэрийг энэ хууль болон Компанийн тухай хуулийн хүрээнд гаргаж” гэж заажээ. Энэ нь төрийн өмчийн удирдлагын эрхийг хувьцаа эзэмшигчийн эрхээс зааглах зарчмын ач холбогдолтой зохицуулалт юм. Гэсэн хэдий ч энэхүү зарчмыг бодит байдал дээр хэрэгжүүлэхийн тулд хуулийн төслийн тодорхой зохицуулалтуудыг энэхүү зарчимтай уялдуулан төрийн өмчийн удирдлагын эрхийг хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээний хүрээнд хязгаарлаж өгөх нь чухал. Энэхүү суурь зарчимтай зөрчилдсөн хэд хэдэн зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсаныг дор дурдсан болно.
2. Өмчлөгч буюу төрийн эрх хэмжээ нь хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхээр хязгаарлагдаж, тухайн бүрэн эрхээ хуульд заасны дагуу хэрэгжүүлэх	
Тодорхой хэмжээнд нийцсэн	Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх агуулгын хүрээнд Засгийн газар, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллагын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчийн эрхийн хүрээнд тодорхойлохыг эрмэлзсэн нь ажиглагдаж байна. Гэвч анхаарах ёстой хэд хэдэн асуудал байгааг мөн дор дурдав.
Нийцээгүй	Хуулийн төслийн 16 дугаар зүйлд компанийн тодорхой шийдвэрт хориг тавих эрхтэй “Алтан хувьцаа”-ны зохицуулалтыг тусгажээ. “Алтан хувьцаа” нь Компанийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт тусгагдсан ба цаашид компанийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зарим тодорхой шийдвэрт хориг тавих боломжийг олгодог хувьцааны төрөл юм. “Алтан хувьцаа” нь хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын тодорхой шийдвэрт шууд хориг тавих боломжтой байдгаараа компанийн эрх мэдлийн хуваарилалтаас давсан бүрэн эрхийг алтан хувьцаа эзэмшигч буюу төрд олгож байдаг. Тиймээс алтан хувьцаа зохистой эсэхийг компанийн эрх мэдлийн хуваарилалтын үүднээс нягталж үзэх нь зүйтэй.

36 OECD, Owner and Governance of State-Owned Enterprises: A Compendium of National Practices (2021).

Нийцээгүй	Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2.6-д зааснаар “төрийн өмчийн компанийн үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийг шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх, худалдах, солих шийдвэр гаргах” бүрэн эрхийг Засгийн газарт олгосон нь эдгээр компанийн эд хөрөнгийн талаарх хувьцаа эзэмшигчдийн хурал хийгээд ТУЗ-ийн бүрэн эрхийг шууд хязгаарласан шинжтэй байна.
Нийцээгүй	Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2.11-д “нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулах саналыг төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захиралд өгөх” гэж тусгасан нь ТУЗ болон гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг шууд хөндөж байна.
Нийцээгүй	Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2.13-т “хуульд заасан бусад”, 23.1.9-т “хуульд заасан бусад” гэж Засгийн газар болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн бүрэн эрхийг өргөжүүлэх хууль зүйн боломж үүсгэж байна. Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг гагцхүү хуульд тусгах замаар хязгаарлаж өгөх нь зүйтэй.

3. ТУЗ-ийн хараат бус, бие даасан байдлыг хүндэтгэх

Нийцээгүй	Хуулийн төслийн 18 дугаар зүйлд “Үнэт цаас гаргах, зээл авах” асуудлыг зохицуулсан байх бөгөөд ихэнх тохиолдолд санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авах, үнэт цаас гаргах шаардлагыг тусгаж өгчээ. ТБОНТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.16-21.20 дахь хэсэгт заасан үнэт цаас гаргах, зээл авах зөвшөөрлийг төрийн байгууллагаас авах гэсэн шаардлагыг хуулийн төсөлд агуулгыг нь өөрчлөлтгүйгээр тусгасан нь ТУЗ-ийн эрх мэдлийг шууд хязгаарласан шинжтэй байна.
Тодорхой хэмжээнд нийцсэн	Хувьцаа эзэмшигчээс өгөх удирдамжийг баримтлан ажиллахыг ТУЗ-д илэрхий үүрэг болгоогүй нь оновчтой байна. Гэсэн хэдий ч төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын хүрээнд ТУЗ-ийн бүрэн эрхийн асуудлаар удирдамж өгөх боломжтой хэвээр байгааг анхаарах нь зүйтэй.
Нийцээгүй	Хуулийн төслийн 33 дугаар зүйлд тусгасан ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлөх үндэслэлүүд хэт өргөн хүрээтэй байна. Жишээ нь: хуулийн төслийн 33 дугаар зүйлийн 33.1.2-д “компанийг зохистой удирдах шаардлагыг хангахгүй болсон” гэсэн нь хэт тодорхой бус байна. Энэ нь ТУЗ-ийн гишүүн албан тушаалаас чөлөөлөгдөхгүйн тулд хувьцаа эзэмшигчийн эрх ашигт нийцүүлэн хэт туйлширсан үйл ажиллагаа явуулах буюу бүрэн эрхээ бие даан хараат бусаар хэрэгжүүлэх боломжгүйд хүргэх үр дагавар үүсгэх эрсдэлтэй.

4. ТУЗ-ийн бүрэн эрхийг тодорхойлж бэхжүүлэх

Нийцээгүй	Хуулийн төслийн 5 дугаар бүлэг нь “Компанийн удирдлага, зохион байгуулалт” гэх гарчигтай боловч доторх агуулга нь ерөөс компанийн удирдлага, зохион байгуулалтын тухай бус харин ТУЗ-ийн гишүүнийг томилох асуудал болон ТУЗ, гүйцэтгэх захирлын хүлээх үүргийн тухай байна. Зарчмын хувьд ТӨК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ болон гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг нарийвчлан тодорхойлж, тэдгээрийн хоорондын оновчтой хуваарилалт, чиг үүргийн ялгаа заагийг тодорхой болгох нь зүйтэй. Ялангуяа ТУЗ-ийн чиг үүрэг, бүрэн эрх, түүний хүрээнд шийдвэрлэх ёстой асуудлуудыг шууд тодорхойлон заах шаардлагатай боловч энэ талаар тодорхой зохицуулалт алга байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар болон төрийн байгууллагуудын бүрэн эрхийг нэлээд дэлгэрэнгүй тодорхойлсон байх боловч ТУЗ-ийн бүрэн эрхийг нарийвчлан тодорхойлоогүй нь тэнцвэргүй, оновчгүй байна.
------------------	---

5. Компанийг стратегийн удирдлагаар хангах эрх

Нийцээгүй	Хуулийн төсөлд компанийг стратегийн удирдлагаар хангах ТУЗ-ийн эрх тусгагдаагүй.
------------------	--

6. ТУЗ-ийн гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх эрх

Тодорхой хэмжээнд нийцсэн	Хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн компанийн гүйцэтгэх захирлыг төлөөлөн удирдах зөвлөл сонгож, нэг жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллуулна” гэж тусгасан нь ТУЗ-ийн гүйцэтгэх захирлыг томилох бүрэн эрхийг баталгаажуулж өгчээ. Гэвч хуулийн төслийн 38 дугаар зүйлд заасан гүйцэтгэх захирлыг чөлөөлөх үндэслэл нь хэт өргөн хүрээтэй байна.
----------------------------------	--

ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БА ҮҮРГИЙН ЗӨРЧИЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн хариуцлагын өнөөгийн нөхцөл байдал

ТУЗ нь компанийн удирдлагын шийдвэрийг гаргах, гүйцэтгэх удирдлага нь өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах эрх болоод үүрэгтэй. Үүний хариуд ТУЗ-д энэхүү эрхийг хянах зорилгоор компанийн өмнө итгэл даах үүргийг хүлээлгэдэг ба зөрчсөн тохиолдолд хувийн хөрөнгөөр хариуцлага хүлээлгэх механизм үйлчилдэг.

Сүүлийн үед ТӨК-ийг тойрсон (Эрдэнэс Тавантолгой ХК, Хөгжлийн банкттай холбоотой хэргүүд) томоохон хэрэг маргаанууд гарах болсон. Дээрх хэрэг маргааны үндэслэл болсон компанийн голлох шийдвэрүүдийг тухайн компанийн гүйцэтгэх удирдлага болон ТУЗ гаргасан байдаг. Өөрөөр хэлбэл, компанийн эрх бүхий албан тушаалтан болох гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн, гишүүн нь компанийн өмнө итгэл даах үүргийг хүлээх ба гаргасан шийдвэр нь дээрх үүргийг зөрчсөн нь нотлогдвол өөрийн хөрөнгөөр хариуцах учиртай.

Монгол Улсын хувьд компанийн ТУЗ-ийн гишүүнд хариуцлага хүлээлгэх олон механизмаас (эрүүгийн хариуцлага, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, гэм хор учруулснаас үүсэх хариуцлага) итгэл даах үүргийн зөрчлийг тогтоож хариуцлага хүлээлгэх тогтолцоо нь онол болон хууль хэрэглээний хувьд шинэлэг төдийгүй шүүхийн практикт нэгдсэн ойлголт болж хөгжөөгүй байна.

Ялангуяа ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүнд гаргасан шийдвэртэй нь холбоотойгоор итгэл даах үүргийн зөрчилд нь хариуцлага хүлээлгэсэн тохиолдол ховор байна. Учир нь ТӨК-ийн хувьд төрийг төлөөлөн ТУЗ-д ажиллах этгээдийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага томилж, түүнд удирдамж өгөх байдлаар ажиллах чиглэлийг нь тодорхойлдог. Удирдамж, зааврыг зөрчсөн, эсрэг саналтай учраас зохих ёсоор гүйцэтгээгүй зэрэг нь түүнийг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх үндэслэл болдог.

Төр компанийн хэлбэрийг сонгон үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд тухайн компанийн нэгдсэн бодлогыг тодорхойлж чиглэмж өгөх нь

зүйн хэрэг боловч хуульд заасан эрх хэмжээнээс хэтрүүлсэн (*томилгоо хийхийг шаардах, бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар чиглэл өгөх, улс төр, ашиг сонирхлын зөрчил бүхий шийдвэр гаргахыг шаардах зэрэг*) тохиолдолд уг удирдамжийг биелүүлээгүй ТУЗ-ийн гишүүнийг хамгаалах тогтолцоо, мөн хууль бус удирдамж чиглэл өгсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүний хувьд хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхэд нь дараах хүндрэл тулгарах нь түгээмэл байдаг.³⁷ Үүнд:

- Засгийн газар болон төрийн байгууллагын зүгээс компанийн эрх ашигт үл нийцэх бодлого гаргаж, хэрэгжүүлэхийг шаардах;
- ТУЗ-ийн гишүүн нь төрийн албан хаагч байх тохиолдолд төрийн албан хаагчийн үүрэг нь ТУЗ-ийн гишүүний үүрэгтэй нь зөрчилдөх;
- ТУЗ-ийн гишүүн хянамгай байх үүргээ гүйцэтгэх мэдлэг, чадваргүй байх гэх мэт.

Монгол Улсын хувьд бусад улс оронд тулгардаг дээрх хүндрэлүүд ч мөн адил гардаг.

- ТӨК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн нь төрийн захиргааны албан хаагч байх³⁸ тул ТУЗ-ийн гишүүний хувьд компанийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь тодорхой хүндрэл гардаг. Өөрөөр хэлбэл, Засгийн газар, яамдаас ТӨК-ийн эрх ашигт харшлах бодлого хэрэгжүүлэх, улс төрийн нөлөөллөөр дамжуулан тодорхой шийдвэр гаргахыг шаардах нь нийтлэг бөгөөд энэ тохиолдолд ТУЗ-ийн гишүүн нь төрийн захиргааны албан хаагч болохын хувьд ашиг сонирхлын зөрчилд ордог байна. Үүнийг шийдэх нэг арга бол ТУЗ-д ажиллах төрийн албан хаагчдын тоог багасгах эсвэл тодорхой тоон квот тогтоох юм.
- ТӨК-ийн ТУЗ-д хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн баталсан заавар, удирдамжийг баримтлан ажиллах үүрэг хүлээлгэсэн³⁹ нь ТУЗ-ийн компанийн өмнө

37 World Bank, Corporate Governance of State-Owned Enterprise: A Toolkit, 161 (2014).

38 Засгийн газрын тогтоол 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралт, "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам".

39 ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.6. "Төрийн өмчийн төлөөлөгч болон ТУЗ-ийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана. Удирдамж, зааврыг

хүлээх үүрэгтэй зөрчилддөг.

- ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалт хангалтгүй, төрийн албан хаагчид голлон ажилладагаас компанийн өмнө хүлээх үүргээ биелүүлэх мэдлэг, чадвар сул хүмүүс ТУЗ-д орох нь түгээмэл байдаг.
- Компанийн тухай хуульд заасан ТУЗ-ийн гишүүнд гаргасан шийдвэртэй нь холбоотойгоор хүлээлгэдэг итгэл даах үүргийн зөрчлөөс үүдэх хариуцлага⁴⁰, хуульд

заасан тусгай хариуцлагын⁴¹ зохицуулалтыг практикт зөв хэрэглэсэн тохиолдол ховор байна.

Үүнээс дүгнэхэд, ТӨК-ийн ТУЗ-ийн үүрэг хариуцлагын тогтолцоо холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд бүрэн бүрдээгүй гэж дүгнэж болох төдийгүй тэдгээрийн агуулга зарим талаараа компанийн засаглалын суурь зарчмаас гажих, бодит байдал дээр хэрэгжүүлэх боломжгүй байх зэрэг бэрхшээл тулгарч байна.

ТУЗ-ийн гишүүний компанийн өмнө хүлээх үүрэг

ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүн хувийн хэвшлийн компанийн ТУЗ-ийн гишүүний нэгэн адил компанийн эрх ашгийг дээдлэн ажиллах буюу итгэл даах үүргийг хүлээж, түүнийгээ зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх нь компанийн эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоо юм.⁴²

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй тогтвортой явуулахын тулд холбогдох эрх бүхий албан тушаалтныг (ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч) томилон ажиллуулдаг. Энэ нь ТУЗ болон компани хоёрын дунд итгэл дээр (fiduciary relationship) тулгуурласан харилцааг үүсгэдэг.

Үүний эсрэг ТУЗ нь өөрт олгогдсон өргөн хүрээтэй бүрэн эрхийг буруугаар ашиглах, хувьцаа эзэмшигчийн эрх ашигт үл нийцэх шийдвэр гаргах эрсдэл бий болдог. Иймд ТУЗ-ийн компани болон хувьцаа эзэмшигчийн өмнө хүлээх үүрэг болон зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага маш тодорхой байх учиртай.

ТУЗ-ийн гишүүн нь итгэл даах үүргээс үүдэн үнэнч байх үүрэг (duty of loyalty), хянамгай байх үүрэг (duty of care)-ийг давхар хүлээнэ. Тэдгээрийг бүхэлд нь компанийн эрх бүхий албан тушаалтны үүрэг (director's duties, fiduciary duties) гэж нэрлэдэг. Компанийн эрх зүйн хүрээнд дээрх үүргийг ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүн ч нэгэн адил хүлээнэ.⁴³

Хянамгай байх үүрэг нь хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй аливаа үйлдэл хийхгүйн тулд аливаа шийдвэр гаргахдаа болгоомжтой, няхуур хандах гэсэн агуулгатай. Өөрөөр хэлбэл, компани, ялангуяа тухайн шийдвэрт хамаарах асуудлаар бүрэн мэдээлэлтэй байж, мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргахыг шаардана. Мөн хангалттай мэдлэг, чадвартай байж, мэргэжлийн түвшинд ажиллах, олон ТУЗ-д давхар ажиллахгүй байх зэрэг нь тус үүрэгт хамаарна.

Харин үнэнч байх үүргийг компанид үнэнчээр ажиллах үүрэг гэж ойлгох бөгөөд компани болон хувьцаа эзэмшигчийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах, компанийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавих агуулгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, ТУЗ нь улс төрийн нөлөөлөл болон бусад этгээдийн ашиг сонирхлоос компанийн эрх ашгийг тэргүүнд тавина гэсэн үг юм. ЭЗХАХБ-аас ТӨК-ийн ТУЗ-д дээрх үүргүүдийг хүлээлгэн холбогдох хууль тогтоомжид тусгахыг зөвлөсөн байдаг.⁴⁴

зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно”.

40 Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.6. “Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.”

41 Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.2. “Компанийн эрх бүхий албан тушаалтан дор дурдсан хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.”

42 OECD, Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises, OECD Publishing (2015)

43 A Toolkit, supra note 37, at 161.

44 OECD, Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises, OECD Publishing (2015)

(§7A) ТУЗ-ийн гишүүн нь үнэнч шударга ажиллах ба гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээх үүрэгтэй.

Хүснэгт 6. Итгэл даах үүргийн харилцааг зохицуулсан зарим орны туршлага

	Компанийн тухай хууль (2011)	Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам (2023)	ТБОНӨКТХ-ийн төсөл (2022) ⁴⁵	АНУ-ын Компанийн загвар хууль (2016) ⁴⁶	ХБНГУ-ын Хувьцаат компанийн тухай хууль (1900) ⁴⁷	Индонез Улсын Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, үүсгэн байгуулах, татан буулгах журам (2003) ⁴⁸
Хянамгай байх үүрэг	(§ 84.4.1) Хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллах, эрх мэдлээ хэрэгжүүлэх; (§ 84.4.3) Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;	(§ 6.1.2) Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас оролцож, шийдвэр гаргахад санал өгөх; (§ 6.1.3.) Шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээлэлтэй танилцсан байх, бүрэн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах;	(§32.4.1.) ТУЗ-ийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд оролцож, шийдвэр гаргахад саналаа өгөх; (§ 32.4.3.) Шийдвэр гаргахад шаардагдах бүх мэдээлэлтэй танилцах, бүрэн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах;	(§ 8.30.b) ТУЗ-ийн гишүүд эсхүл ТУЗ-ийн хорооны гишүүд шийдвэр гаргах чиг үүрэг болон хяналт тавих чиг үүрэг хэрэгжүүлэхдээ мэдээлэлд тулгуурлан, тухайн нөхцөл байдалд адил түвшний албан тушаалтан зохиистой гэж итгэх түвшинд хянамгай байж өөрсдийн чиг үүргээ хэрэгжүүлбэл зохино.	(§ 93/1.1) ТУЗ-ийн гишүүн нь шийдвэр гаргахдаа хуульд заасан үүргээ үнэнчээр биелүүлж, хянамгай хандаж ажиллана.	(§ 26. 2) ТУЗ нь аливаа шийдвэр гаргахдаа хянамгай байж, бүрэн мэдээлэлд тулгуурлан ТӨК-ийн чиг үүрэг, зорилгод нийцсэн шийдвэр гаргана.
Үнэнч байх үүрэг	(§ 84.4.4) Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх; (§ 84.4.5) Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгүйн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх; (§ 84.4.2) Үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх; (§84.4.6) Компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх;	(§ 6.1.4.) ТУЗ-ын гишүүний бүрэн эрх, чиг үүрэг, нөлөөг урвуулан ашиглах, компанийн талаарх мэдээ, мэдээлэл, бизнесийн нууц, хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;	(§ 32.4.6.) Өөрөө, эсхүл түүний хамаарал бүхий этгээд дангаараа, эсхүл хамтран компанийн хувьцаа эзэмшигч болсон даруйд мэдэгдэх. (§ 32.4.1.) Эрх, үүргээ үнэнч шударгаар, зөвхөн компанийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх; (§32.4.4.) ТУЗ-ын гишүүний бүрэн эрх, чиг үүрэг, нөлөөг урвуулан ашиглах, компанийн талаарх мэдээ, мэдээлэл, бизнесийн нууц, хөрөнгийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх (§32.4.5.) Өөрийн албаны чиг үүргээс ТУЗ-ийн гишүүний чиг үүрэг тусгаарлагдсан байх;	(§ 93/1.3) ТУЗ-ийн гишүүн нь албан үүргийн хүрээнд олж авсан компанийн нууц, нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх;	(§ 27. 1) ТУЗ-ийн гишүүн бүр ТӨК-ийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж, үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэх;	

45 Засгийн газраас өргөн мэдүүлсэн "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай" хуулийн төсөл, Дэлгэрэнгүй <https://lawforum.parliament.mn/project/170/>

46 Model Business Corporation Act (2003)

47 Aktiengesetz -1965

48 The Establishment, Management, Supervision and Dissolution of State Owned Enterprises. Government Regulation No. 23 /2022.

Дээрхээс дүгнэхэд Монгол Улсын холбогдох хууль, журамд ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүний итгэл даах үүргийн нэг хэсэг болох хянамгай байх болон үнэнчээр ажиллах үүргүүд тусгагдсан байна.

Итгэл даах үүргийн хамрах хүрээ нь өргөн бөгөөд улс орон бүр харилцан адилгүй байдлаар хуульчилсан байна. Бусад улс орны эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд ТУЗ-ийн гишүүнд итгэл даах үүргээс нь үүдэн хариуцлага хүлээлгэх тогтолцоог ТӨК-ийн харилцааг тухайлан зохицуулсан хууль, журам⁴⁹ эсвэл компанийн харилцааг зохицуулсан ерөнхий хуулийн⁵⁰ аль нэгэнд тусгах байдлаар зохицуулсан байна.

Монгол Улсын хувьд Компанийн тухай хууль,

Итгэл даах үүргийн зөрчлийг тогтоох

ТУЗ-ийн гишүүд нь итгэл даах үүргээ зөрчин компанид хохирол учруулсан гэж үзвэл хувьцаа эзэмшигчийн зүгээс хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Хянамгай байх үүргийн зөрчлийг бизнесийн шийдвэр гаргах дүрэм (business judgment rule) гэж нэрлэгдэх шалгуурын дагуу үнэлэн тогтоодог. Харин үнэнчээр ажиллах үүргийн зөрчилд үндэслэн нэхэмжлэл гаргах тохиолдолд үнэнч

Хянамгай байх үүргийн зөрчлийг тогтоох

ТУЗ-ийн гишүүнд олон янзын, тодорхойгүй үүрэг, хариуцлага хүлээлгэх нь тухайн этгээдийн ажиллах сэдлийг бууруулах эрсдэлтэй ба ямар нэгэн эрсдэл бүхий үйл ажиллагаа явуулахаас зайлсхийж, аюулгүй, эрсдэл гаргахгүй байхад илүү ач холбогдол өгч эхэлдэг байна.⁵¹ Мөн ТУЗ нь хуульд заасан үүргийн хүрээнд зохих ёсны шийдвэр гаргасан ч түүний үр дагаварт компани алдагдал хүлээх ч тохиолдол бас бий. Энэ тохиолдолд ТУЗ шийдвэр гаргахдаа хянамгай байх үүргээ чандлан биелүүлсэн л бол хариуцлагаас чөлөөлөгдөх нь шударга ёсны зарчимд нийцэх юм.

Иймд хянамгай байх үүргээ зөрчсөн эсэхийг

Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам, Төрийн болон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл зэрэг хууль тогтоомжид итгэл даах үүргийг давхардуулан, олон утга санаагаар хуульчилсан байгаа нь ерөнхий хууль ба тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан тусгай хуулийн хооронд эрх зүйн зөрчил үүсэх, улмаар хууль хэрэглээнд хүндрэл учруулах эрсдэл үүсгэж байна. Иймд ТУЗ-ийн гишүүний итгэл даах үүрэг түүнээс үүсэх хариуцлагын асуудал нь ТӨК болон хувийн хэвшлийн компанийн аль альд хамаарах ерөнхий үүрэг учир ерөнхий хууль болох Компанийн тухай хуульд тодорхой системчлэн оруулах нь үр дүнтэй юм.

шударгаар шийдвэр гаргасан (entire fairness) байдлыг нь үнэлэх замаар зөрчлийг тогтооно. ТУЗ нь шийдвэр гаргахдаа итгэл даах үүргээ биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд нотлох үүргийг нэхэмжлэгч этгээд болох хувьцаа эзэмшигч хүлээх ба шүүхийн зүгээс ТУЗ-ийн шийдвэр нь итгэл даах үүргийг зөрчсөн эсэхийг үнэлэн тогтоох юм.

тогтоохдоо бизнесийн шийдвэр гаргах дүрмийн дагуу үнэлгээ хийх ба энэ ойлголт нь Англи-Америкийн эрх зүйгээс үүсэлтэй, АНУ-ын улсын шүүхийн жишигт тулгуурлан хөгжсөн ойлголт юм.⁵²

Бизнесийн шийдвэр гаргах дүрэм нь тухайн нөхцөл байдалд бусад компанийн удирдлага ч авч хэрэгжүүлэх байсан буюу мэдээллийг бүрэн цуглуулж, түүнд үндэслэн шийдвэр гаргахдаа хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьсан бол хожим нь тухайн шийдвэр оновчтой бус байсан ч хянамгай байх үүргээ зөрчсөн гэж үзэхгүй.⁵³ Өөрөөр хэлбэл, ТУЗ-ийн гишүүн нь шийдвэр гаргахдаа, шударга,

49 Индонез Улс нь 2022 онд ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүнд гаргасан шийдвэртэй нь холбоотойгоор хувийн хөрөнгөөр хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг холбогдох журамдаа шинээр тусгажээ

50 ХБНГУ, АНУ, Англи гэх мэт

51 江頭憲治郎『株式会社法』434頁参照(有斐閣 第7版 2017年)。

52 Kürşat Gökürk, Amerikan, Alman, İsviçre ve Türk hukukunda işadami kararı ilkesi, İnönü Üniversitesi Hukuk Fakültesi Dergisi Cilt:2 Sayı:2, s.208 (2011)

53 江頭・前掲注(51 471頁参照)。

бас няхуур хянамгай байж, ижил төстэй бусад компанийн удирдлагатай адил хэмжээнд нухацтай хандсан бол ямар нэг хариуцлага хүлээхгүй байх зарчим юм.

Ихэнх улсад ТУЗ-ийн гишүүн тухайн асуудалд судалгаатай хандаж, бүх дүрэм журмыг баримтлан шийдвэр гаргасан тохиолдолд хянамгай байх үүргээ зөрчсөн гэж үздэггүй байна.⁵⁴

Шийдвэр гаргахдаа бизнесийн шийдвэр гаргах дүрмийг баримталсан эсэхийг харилцан адилгүй шалгуураар тогтоодог ч дараах 5 үндсэн нөхцөлийг нийтлэг байдлаар хэрэглэдэг.⁵⁵ Үүнд:

- Гаргасан шийдвэр нь тухайн нөхцөл байдалд хамгийн зөв шийдвэр гэж үзсэн байх (conscious business decision);
- ТУЗ-ийн гишүүн нь сонирхлын зөрчилгүй, хараат бусаар бие даан шийдвэр гаргасан байх (disinterested and independent);
- Компанийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж, үнэнч шударгаар хандсан байх (good faith);
- Хангалттай мэдээлэлд тулгуурласан байх (an informed decision);
- Хууль болон компанийн дүрмийг зөрчөөгүй байх (illegality).

Дээрх нөхцөлүүд хангагдсан тохиолдолд ТУЗ-ийн гишүүн нь гаргасан шийдвэртэйгээ холбоотойгоор ямар нэг хариуцлага хүлээх учиргүй.

Монгол Улсын хувьд бизнесийн шийдвэр гаргах дүрэм буюу мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах, ингэхдээ хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих зэрэг шалгуураар ТУЗ-ийн шийдвэрийг үнэлэх, улмаар хариуцлага хүлээлгэх, эсхүл хариуцлагаас чөлөөлөх агуулга бүхий зохицуулалт Компанийн тухай болон бусад холбогдох хуульд тусгагдаагүй байна. Компанийн тухай хуулиар ТУЗ-ийн гишүүнд компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах (84.4.3) үүргийг хүлээлгэсэн хэдий ч ТУЗ-ийн шийдвэр компанийн эрх ашигт нийцсэн, мөн үндэслэлтэй эсэхийг хэрхэн тогтоох нь тодорхойгүй тул үүнийг зөвхөн шүүх л тогтоох боломжтой байна. Гэвч шүүх мөн адил ямар шалгуурын хүрээнд ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэлтэй эсэхийг үнэлэн тогтоох

нь тодорхойгүй байна.⁵⁶

ТУЗ-ийн гишүүний хянамгай байх болон үнэнч байх үүргийн зөрчлийг тогтоож хариуцлага хүлээлгэхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) болон Улсын Их Дэлгүүр ХК-ийн хооронд үүссэн маргааныг дурдаж болно.

Хэргийн товч агуулга⁵⁷

СЗХ-оос Б нарын есөн хүнд холбогдуулан “УИД” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 7 болон 2017 оны 6 дугаар тогтоолуудыг хүчингүй болгож, уг тогтоолыг үндэслэж “УИД” ХК болон “НР” ХХК-ийн байгуулсан 2016 оны гэрээ, түүний сунгасан 2017 оны гэрээ, 2018 оны үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг тус тус хүчин төгөлдөр бус хэлцэл болохыг тогтоолгох, компанид учруулсан 4.4 тэрбум төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаас гаргуулах нэхэмжлэлийг гаргасан байна.

Хэрэгт авагдсан баримтын хүрээнд “УИД” ХК-ний ТУЗ-ийн 2015 оны 7, 2017 оны 6 дугаар тогтоолоор “НР” ХХК-тай сонирхлын зөрчилтэй түрээсийн гэрээ байгуулж компанийг алдагдалд оруулж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироосон, мөн хараат бус гишүүн Д нь сонирхлын зөрчилтэй атлаа санал хураалтад оролцсон болох нь тогтоогдсон байна. Тус гэрээний хүрээнд “УИД” ХК нь “НР” ХХК-тай 1 сарын 450,000,000 төгрөгийн үнэ бүхий түрээсийн гэрээ байгуулсан байна. “НР” ХХК нь “УИД” ХК-тай гэрээ байгуулсны дараа “НТ” ХХК-д 1 сарын 800,000,000 төгрөгөөр дамжуулан түрээсэлсэн ба улмаар “НТ” ХХК нь жижиглэнгийн түрээслэгч нартай 2016 онд 8,756,600,000 төгрөгийн, 2017 онд 8,868,900,000 төгрөгийн, 2018 онд 10,025,200,000 төгрөгийн түрээсийн гэрээг тус тус байгуулсан болох нь тогтоогдсон байна.

54 G20/OECD, Компанийн засаглалын зарчмууд, монгол хэл дээрх орчуулга, 53 тал (2015)

55 Model Business Corporation Act 8.31 (a).

56 Г.Давааням, Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт, 97 тал (2021)

57 Улсын Дээд Шүүхийн Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2023/07/04/, Дугаар 001/ХТ2023/00147

Шийдвэрийн товч агуулга⁵⁸

1. Түрээслэгч “НР” ХХК нь сарын 450,000,000 төгрөгийн үнэ бүхий түрээсийн гэрээ байгуулмагц “НТ” ХХК-д сарын 800,000,000 төгрөгийн төлбөртэйгөөр дамжуулан түрээслүүлсэн, “НТ” ХХК нь цаашир жижиглэнгийн түрээслэгч нар т дамжуулан 2016 онд 8,756,600,000 төгрөгийн, 2017 онд 8,868,900,000 төгрөгийн, 2018 онд 10,025,200,000 төгрөгийн түрээсийн гэрээ байгуулсан нь үнийн хувьд илт зөрүүтэй, компанийн эрх ашигт нийцээгүй байна. Иймд ТУЗ-ийн гишүүд үүргээ шударгаар биелүүлсэн гэж үзэх боломжгүй.
2. ТУЗ-ийн дарга Э, Х, хараат бус гишүүн Ч, Д, Б нар нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх замаар Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах шийдвэр гаргаж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцохдоо компанийг алдагдалд оруулж, компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 31.46%-ийг эзэмшиж буй 45,000 гаруй жижиг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахгүй байгаа нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхлыг бодит байдлаар хохироосон байна. “УИД” ХК-ний ТУЗ нь Компанийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж бие даасан байдлаар хангаж ажиллаагүйн улмаас 2017 оны 04 дүгээр сараас 2018 оныг дуустал хугацаанд жилд дунджаар түрээсийн орлого 11,4 тэрбум төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардал 7,6 тэрбум төгрөг, татварын дараах цэвэр ашиг 2,9 тэрбум төгрөг, мөн 2017 оны 4 дүгээр сараас 2018 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд татварын дараах цэвэр ашиг 4,416,400,000 төгрөг олох боломжийг алдагдуулсан болохыг тогтоосон байна.
3. Компани ашиг олох, засаглалаа бэхжүүлэх, зохистой ажиллах нөхцөлийг хангахын тулд компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх итгэлцлийн үүргийг хуулиар, мөн компани дүрмээрээ тогтоож болохыг зохицуулсан. “УИД” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 7, 2017 оны 6 дугаар тогтоолоор сонирхлын зөрчилтэй түрээсийн гэрээ

байгуулсан нь компанийг алдагдалд оруулж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироосон, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д зааснаар ТУЗ-ийн гишүүд нь компанийн эрх бүхий албан тушаалтан бөгөөд Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т заасан “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, 84.4.4-т заасан “шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх” үүргээ биелүүлээгүй. Эдгээр үүрэг нь ТУЗ-ийн бүх гишүүнд хамааралтай тул ТУЗ-ийн гишүүд болох хариуцагч нар энэ үүргээ биелүүлээгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

4. Хариуцагч Б, Ш, С, Н, А, Х нар Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т заасан үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх, үндэслэлтэй шийдвэр гаргах үүргээ биелүүлээгүй, мөн хуулийн 84 дүгээр зүйлийн 84.6-д зааснаар хараат бус гишүүд Д, Б нар Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2, 92 дугаар зүйлийн 92.2, 55 дугаар зүйлийн 55.3-т заасан үүргээ тус тус биелүүлээгүй тул хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1-д зааснаар тус тус хохирлыг хариуцах үндэслэлтэй байна.
5. Хараат бус гишүүдээс гадна ТУЗ-ийн бусад гишүүд ч компанийн эрх ашигт нийцээгүй тогтоолыг дэмжсэн, үндэслэл бүхий шийдвэр гаргах үүргээ биелүүлээгүй, бие даасан байдлаар хангаж ажиллаагүй тул хариуцлагыг хамтран хүлээх үндэслэлтэй болно.

Иймд нэхэмжлэлийн шаардлагад дурдсан “УИД” ХК-ийн ТУЗ-ийн тогтоолуудыг хүчингүй болгож, түрээсийн гэрээнүүдийг хүчин төгөлдөр бус болохыг тогтоож, Компанийн тухай хуулийн 84 дүгээр

⁵⁸ Хэсэгчлэн авав.

зүйлийн 84.6, 90 дүгээр зүйлийн 90.1 дэх хэсэгт зааснаар буруутай албан тушаалтнууд болох хариуцагч тус бүрээс 440 сая төгрөгийг гаргуулж, “УИД” ХК-д олгохоор шийдвэрлэсэн байна.

Бизнесийн шийдвэр гаргах дүрмийн агуулгыг улс орон бүр харилцан адилгүй байдлаар хуульчилсан байдаг ба дараах үндсэн шинжийг голчлон авч үзсэн байдаг.

Индонез Улс: ТӨХЭ-ийн удирдлага, хяналт, үүсгэн байгуулах ба татан буулгах журам

§ 59. Дараах нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд ТУЗ-ийн гишүүд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

59.1. Үнэнч шударга, хянамгай байж ТӨК-ийн зорилго чиглэлд нийцсэн, эрх ашгийг дээдэлсэн шийдвэр гаргасан;

59.2. Гаргасан шийдвэрийн үр дагавартай шууд болон шууд бусаар хувийн ашиг сонирхолгүй байх;

59.3. Шийдвэрийн үр дагавартай холбоотой эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөгөө мэдээлэл авсан байх.

ХБНГУ: Хувьцаат компанийн тухай хууль

§ 93/1,2. ТУЗ-ийн гишүүн нь бизнесийн шийдвэр гаргахдаа хангалттай мэдээлэлд тулгуурлан, компанийн эрх ашгийг эн тэргүүнд тавьж шийдвэр гаргасан тохиолдолд үүргээ зөрчсөн гэж үзэхгүй.

ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүн нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн эрх бүхий байгууллагын өгсөн удирдамжийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ хүрээнд Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн

өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журамд ТУЗ-ийн гишүүнийг хамгаалах зорилгоор хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн заавар, удирдамжийн дагуу гарсан аливаа шийдвэрийн үр дагаврыг ТУЗ-ийн гишүүн хариуцахгүй байх зохицуулалт оруулж өгчээ.⁵⁹

Дээрх зохицуулалт нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн заавар, удирдамжаас үүдэлтэй аливаа хохирлыг ТУЗ хариуцахгүй байх агуулгыг илэрхийлнэ. Гэтэл илтэд компанийн эрх ашигт хохирол учруулж болохуйц эсвэл авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болохуйц шийдвэр гаргаж биелүүлэхийг шаардсан тохиолдолд ТУЗ дээрх шийдвэрийг биелүүлэх ёстой юу, хэрэв биелүүлсэн тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөх үү гэсэн асуудал урган гарч байна.

Зарим орны Компанийн тухай хууль тогтоомжид хувьцаа эзэмшигчдийн хурлын (ТӨК-ийн хувьд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч) шийдвэрийг хэрэгжүүлснээр ТУЗ-ийн гишүүн хувийн хариуцлага хүлээх нөхцөл бүрдэнэ гэж үзсэн тохиолдолд уг шийдвэрийг биелүүлэхээс татгалзах, мөн хүчин төгөлдөр бусд тооцуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг ТУЗ-ийн гишүүнд олгосон байдаг.⁶⁰ Энэ нь нэг талаараа хууль бус шийдвэрийг биелүүлэхгүй байх эрхийг ТУЗ-д олгож байгаа юм. Нөгөө талаар ТУЗ хэрвээ компанийн эрх ашигт үл нийцэх шийдвэрийг биелүүлэхээс татгалзан шүүхэд гомдол гаргаагүй тохиолдолд хянамгай байх үүргээ зөрчсөн гэж үзэх боломжтой юм. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр нь компанийн эрх ашигт нийцэж буй эсэх, хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээг хэтрүүлсэн эсэхийг үнэлэн үзэх нь ТУЗ-ийн гишүүний компанийн өмнө хүлээсэн хянамгай байх үүрэг юм.

Монгол Улсын хувьд ТУЗ-ийн зүгээс компанийн эрх ашигт үл нийцэх шийдвэрийг биелүүлэхээс татгалзах, хүчин төгөлдөр бусд тооцуулахаар гомдол гаргах эрхийг тодорхойлсон зохицуулалт Компанийн тухай болон бусад холбогдох хуульд байхгүй.

59 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам, (§ 8.3) “Эрх бүхий этгээдээс баталсан удирдамжийн дагуу гарсан хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээс үүсэх үр дагаврыг энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан этгээд хариуцахгүй”.

60 Турк улс, Арилжааны тухай хууль, § 446 .1 (d); ХБНГУ, Хувьцаат компанийн тухай хууль § 245.5

Үнэнч байх үүргийн зөрчлийг тогтоох

Хувьцаа эзэмшигчид компанийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох боломж харьцангуй бага тул хөрөнгө оруулагчид болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад ТУЗ чухал үүрэгтэй. Иймд ТУЗ-ийн гишүүд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ компанийн өмнө үнэнчээр ажиллах үүрэгтэй. Үнэнч байх үүрэг нь өргөн хүрээтэй тул шийдвэр гаргах, тодорхой үйлдэл хийх бүртээ компанийн эрх ашгийг болон өөрийн ашиг сонирхолтой харьцуулан цэгнэж, компанийн эрх ашгийг тэргүүнд тавих ёстой.⁶¹

Шүүх үнэнч байх үүргийн зөрчилтэй холбоотой нэхэмжлэлийг шударга байдлын стандартын (entire fairness) дагуу үнэлнэ. Шүүх ТУЗ-ийн шийдвэр хуульд нийцсэн эсэхийг тогтоохоос гадна шударга бөгөөд бодит нөхцөл байдалд нийцсэн эсэхийг мөн тогтоодог. Ийм төрлийн маргааны хариуцагч болох ТУЗ-ийн гишүүд гаргасан шийдвэрийнхээ бодитой, шударга байдлыг нотлох үүрэгтэй. Үнэнчээр ажиллах үүргийн зөрчлийг тогтоох шалгуур харилцан адилгүй байдаг ч дараах шалгуурыг харгалзан үзэх нь нийтлэг байна.

ТУЗ-ийн гишүүний итгэл даах үүргийн зөрчлөөс үүсэх хариуцлага

ТУЗ-ийн гишүүнд итгэл даах үүргийн зөрчлөөс үүдэн хариуцлагыг хүлээлгэхэд дараах нөхцөлүүд бүрдсэн байхыг шаардана. Үүнд:

- Компанид хохирол учирсан байх;
- Үүргээ биелүүлээгүй буюу ажил үүрэгтээ хайнга хандсан байх;
- Ажил үүрэгтээ хайнга хандсан үйлдэл, эс үйлдэхүй болон хохирол хоёрын хооронд шалтгаант холбоо байх.⁶²

Итгэл даах үүргийн зөрчлөөс үүдэх хариуцлага нь хохирлыг нөхөн төлөх шинжтэй бөгөөд хохирлыг хувийн хөрөнгөөр, хамтын шийдвэр гаргасан тохиолдолд хамтын хариуцлага хүлээж хувь тэнцүүлэн нөхөн төлдөг.

Монгол Улсын хувьд Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.6-д ТУЗ компанийн өмнө хүлээсэн үүргээ зөрчсөнөөс үүдэн учирсан хохирлыг ТУЗ-ийн гишүүн өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх, мөн 85 дугаар зүйлийн 85.2-д

- Гаргасан шийдвэр нь шударга байх (fair dealing);
- Төлбөр тооцооны үнийн дүн бодит байх (fair price);
- Ашиг сонирхлын зөрчилгүй байх (conflict of interest transactions);
- Ажил хэргийн хүрээнд олж мэдсэн компанийн нууц, бизнесийн боломжийг өөрт ашиглахгүй байх (corporate opportunities).

Улс орнууд үнэнч байх үүрэг, түүний төрлүүдийг харилцан адилгүй байдлаар хуульчилсан байна. Манай улсын хувьд Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т компанийн эрх ашгийг дээдлэх, 84.4.4-т сонирхлын зөрчлөөс зайлсхийх, 84.4.5-т хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх, 84.4.6-д нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх, 87 дугаар зүйл их хэмжээний хэлцэл хийх, 89 дүгээр зүйлд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зэрэг үнэнч байх үүргийн төрлүүдийг тусгасан байна.

компанийн эрх бүхий албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас гуравдагч этгээдэд (зээлдүүлэгч) хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр нөхөн төлөх хариуцлагыг тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл, Компанийн тухай хуульд ТУЗ-ийн гишүүн хуульд заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх хохирлыг нөхөн төлүүлэх зохицуулалт тодорхой тусгагдсан байна.

Мөн Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.7-д ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь итгэл даах үүргээ биелүүлээгүй бол компанийн хувьцаа эзэмшигч уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг, мөн 86 дугаар зүйлд хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг тус тус хуульчилсан байдаг. Компанийн тухай хуулийн дээрх зохицуулалт хувийн хэвшлийн эсвэл төрийн өмчит компани байхаас үл хамааран үйлчлэх ёстой юм. Өөрөөр хэлбэл, ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүний итгэл даах үүргийн зөрчилд Компанийн тухай хуулиар хариуцлага

61 Hasan Pulaşlı, Şirketler Hukuku Şerhi, s.1159 (2017).

62 Г.Давааням, өмнөх эшлэл 56, 103 тал.

хүлээлгэх бүрэн боломжтой.

Гэвч төр болон төрийн эрх бүхий байгууллагын (хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага) зүгээс ТӨК-д учруулсан хохирлыг ТУЗ-ийн гишүүнээр нөхөн төлүүлэхээр шүүхэд гомдол гаргасан тохиолдол ховор байна. Энэ нь хэд хэдэн шалтгаанаас үүдэлтэй байж болох юм.

- ТУЗ-ийн гишүүний итгэл даах үүргийн зөрчлөөс үүдсэн хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэл нь хувийн эрх зүйд хамаарах тул шүүх зөвхөн талуудын хүсэлтээр буюу нэхэмжлэл хүлээн авсан тохиолдолд хэрэг үүсгэнэ. Иймд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн зүгээс гомдол гаргаагүй тохиолдолд шүүх тухайн асуудлыг шалгахгүй.
- Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн эрх бүхий байгууллага ийнхүү ТУЗ-ийн гишүүнээр хохирол нөхөн төлүүлэх асуудалд идэвхгүй хандах шалтгаан нь ТУЗ-д удирдамж зааварчилгаа өгч шийдвэр гаргахыг шаардсан этгээд нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч өөрөө байх нь бий.
- ТӨК-д холбоотой олны анхаарал татсан томоохон хэргүүдийн ард байх голлох шийдвэрийг ТУЗ болон гүйцэтгэх удирдлага гаргасан байдаг тул Компанийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж, хохирлыг нөхөн

төлүүлэх боломжтой хэдий ч дээрх хэрэг маргаан нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг (хахууль авах, өгөх, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах) агуулж байгаа тул эрүүгийн хэргийн шүүхээр эцэслэн шийдэгдэх нь нийтлэг байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.6-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх журам, хариуцлагын хэмжээг тогтоох аргачлалыг компанийн дүрэмд тусгасан байна.” гэж заасан нь ТУЗ-ийн гишүүний үүрэг хариуцлагыг сайжруулахад чиглэсэн шинэлэг зохицуулалт болсон байна. Гэвч ТУЗ-ийн гишүүний буруутай үйл ажиллагааг тогтоох, хохирлын хэмжээг тодорхойлох асуудал нь компанийн дотоод асуудал гэхээс илүүтэйгээр хуулиар зохицуулагдвал зохих харилцаа юм.

Иймд хохирол нөхөн төлүүлэх журам, хариуцлагын хэмжээг тогтоох аргачлалыг компанийн дүрмээр бус харин Компанийн тухай хуульд тодорхой тусгаж, түүнийг нь шүүх зөв тайлбарлан хэрэглэснээр бодит байдалд бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Хүснэгт 7. Итгэл даах үүргийн зөрчлөөс үүсэх хариуцлагын зохицуулалт

Компанийн тухай хууль (2011)	Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам (2023)	ТБОНӨКТХ-ийн төсөл (2022)	Индонез: Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, үүсгэн байгуулах ба татан буулгах журам (2003)	ХБНГУ: Хувьцаат компанийн тухай хууль (1900)
<p>Компанийн эрх бүхий өмнө хүлээх хариуцлага</p> <p>(КТХ § 84.6)</p> <p>Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуульд заасан хянамгай байх үүрэг болон үнэнч байх үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.</p> <p>(КТХ § 84.9) Энэ хуулийн 84.4-т заасныг зөрчин шийдвэр гаргасан албан тушаалтнууд хамтын хариуцлага хүлээх бөгөөд хохирлыг тэнцүү хэмжээгээр нөхөн төлнө.</p>	<p>(§4.8.) Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн нь дараах үйлдлийн улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.</p> <p>(§4.7.3) хууль, энэ журам болон компанийн дүрэмд заасан үүргээ зохих ёсоор үнэнч шударгаар гүйцэтгээгүй, эсхүл ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр удаа дараа хангалтгүй үнэлэгдсэн, компанийг зохистой удирдах шаардлагыг хангахгүй болсон;</p> <p>(§4.7.5) хууль, энэ журам болон компанийн дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэл хийсэн;</p> <p>(§4.7.6) гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээс тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;</p>	<p>(§33.2.) Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн энэ хуулийн 33.1.2, 33.1.3, 33.1.4, 33.1.5-д заасан үйлдлийн улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.</p>	<p>(§27.2) Хуульд заасан үүргээ гүйцэтгэхдээ, хянамгай байх үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон тохиолдолд ТУЗ-ийн гишүүн бүр хувийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.</p> <p>(§27.2) Итгэл даах үүргээ санаатай болон болгоомжгүйгээр гүйцэтгээгүй тохиолдолд ТУЗ-ийн гишүүн бүр хувийн хөрөнгөөр хариуцна.</p>	<p>(§93.2) Үүргээ зохих ёсоор биелүүлээгүй ТУЗ-ийн гишүүн компанид учирсан хохирлыг нөхөн төлж хамтын хариуцлага хүлээнэ.</p> <p>Үүргээ үнэнч шударгаар биелүүлж, шийдвэр гаргахдаа хянамгай байж чадаагүй гэж үзсэн тохиолдолд тухайн этгээд нотлох үүргийг хүлээнэ.</p> <p>ТУЗ-ийн гишүүний мэргэжлийн үйл ажиллагаанаас учирч болох эрсдэлээс хамгаалах зорилгоор даатгалд хамруулах бол хохирлын 10-аас доошгүй хувийг барагдуулах, ТУЗ-ийн гишүүний жилийн цалингийн 150 хүртэлх хувиар даатгуулж болно.</p>

Нөлөө бүхий этгээдэд хүлээлгэх хариуцлага

ТУЗ нь компанийн голлох шийдвэрийг гаргадаг бүтэц билээ. Энэ утгаараа компанийн томоохон хувьцаа эзэмшигчээс ТУЗ-ийн шийдвэрт нөлөөлөх боломж их юм. ТӨК-ийн хувьд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч болон түүний төлөөлөгч, төрийн байгууллагын зүгээс ТУЗ-ийн гишүүнд удирдамж чиглэл өгөх эрхтэй тул ТУЗ-ийн гишүүнд ийнхүү зааварчилгаа, чиглэл, удирдамж өгөх замаар шийдвэр гаргахад нь хөндлөнгөөс нөлөөлөх боломжтой этгээд давхар хариуцлага хүлээх нь чухал юм.

Монгол Улсын хувьд ТӨК-ийн удирдлагад төрийн байгууллага, албан тушаалтан удирдамж, чиглэл өгөх, ашиг сонирхлын зөрчил бүхий шийдвэр гаргахыг тулгах зэргээр нөлөөлөх явдал түгээмэл гардаг. Иймд ТӨК-ийн ТУЗ-ийн шийдвэрт хөндлөнгөөс нөлөөлж буй этгээдийг тодорхойлж, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.⁶³

Нөлөө бүхий этгээд гэдэгт ТУЗ-ийн гишүүн биш боловч ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргах үйл явцад шууд болон шууд бус байдлаар нөлөөлөх боломжтой этгээдийг ойлгох бөгөөд Английн эрх зүйд үүнийг далд удирдлага, сүүдрийн удирдлага буюу “shadow director”, ди факто удирдлага буюу “de facto organs” гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл компанийн удирдлагын албан ёсны бүтцэд хамаарахгүй боловч өөрийн эрх мэдэл, нөлөөллөө ашиглан компанийн шийдвэрт нөлөөлөх боломжтой этгээд юм.⁶⁴

Нөлөө бүхий этгээд бий болох дараах нөхцөл байдаг. Үүнд: а) толгой компани болон

охин компанийн харилцаанд, б) нэг хувьцаа эзэмшигчтэй компани ба ТУЗ-ийн харилцаанд, в) ТӨК-ийн хувьд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн байгууллага ба ТУЗ-ийн гишүүний харилцаанд тус тус гарах боломжтой.

ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл явцад оролцож буй бүх субъектийг нөлөө бүхий этгээд гэж үзэхгүй бөгөөд нөлөө бүхий этгээдийг дараах шалгуураар тогтоож болно. Үүнд:

- Компанийн удирдлагын шийдвэрт шууд болон шууд бус хэлбэрээр нөлөөлөх боломжтой байх (ТУЗ-ийн хуралд биечлэн оролцох эсвэл ТУЗ-ийн гишүүнд шууд чиглэмж өгөх боломжтой)
- Шийдвэр гаргах түвшний албан тушаалтанд нөлөөлсөн байх (ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага)
- Нөлөөнд автсан этгээд нь тухайн шийдвэрийг (хамтаар гаргах шийдвэр) гаргахад голлох нөлөөллийг үзүүлэх боломжтой байх
- Нөлөөлөл үзүүлэх үйлдэл нь нэг удаагийн болон байнгын шинжтэй байх.

Хэрэв дээрх шалгуурыг хангасан тохиолдолд нөлөө бүхий этгээд гэж тооцох боломжтой юм.⁶⁵

Нөлөө бүхий этгээдийг тогтоосон тохиолдолд түүнд ТУЗ-ийн гишүүний нэгэн адил хариуцлага хүлээлгэх боломжтой юм. Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд нөлөө бүхий этгээдийг тодорхойлж түүнд хариуцлага хүлээлгэх боломж хараахан бүрдээгүй. Бусад улс орнуудын хувьд дараах эрх зүйн зохицуулалт үйлчилдэг байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Нөлөө бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэж буй зарим улсын жишиг

№	Хуулийн зохицуулалт
1	Англи Англи Улсын Компанийн хууль (Company act)-д нөлөө бүхий этгээд (shadow director)-ийг ерөнхий хүрээнд нэрлэж томъёолсон байдаг ба зөвхөн түүнд хамаарахгүй тохиолдлыг нарийвчлан заасан байдаг. ⁶⁶ §251. Нөлөө бүхий этгээд (1) Нөлөө бүхий этгээд гэдэг нь компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор компанийн удирдлагад зааварчилгаа өгч заншсан этгээдийг хэлнэ. (2) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд зөвхөн өөрт нь зориулан мэргэжлийн зөвлөгөө өгсөн бол тухайн этгээдийг нөлөө үзүүлсэн этгээд гэж үзэхгүй.

63 Г.Давааням, Ц. Золбоо, М.Түвшинжаргал, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд өгөх санал шүүмж, Нээлттэй Нийгэм Форум, 2 тал, (2023)

64 Ömer KORKUT, Anonim şirketlerde fili yönetim kurulu üyeliği, Çukurova Üniversitesi Dergisi, s.1367 (2010)

65 Kürşat Göktürk, Amerikan, Alman, İsviçre ve Türk hukukunda işadami kararı ilkesi, İnönü Üniversitesi Hukuk Fakültesi Dergisi Cilt:2 Sayı:2, s.208 (2011)

66 Г.Давааням, Ц. Золбоо, М.Түвшинжаргал, өмнөх ишлэл 63, 2 тал.

Германы эрх зүйд ТУЗ дахь нөлөө бүхий этгээдийг шууд тодорхойлсон зохицуулалт байхгүй ч Хувьцаат компанийн тухай хуульд (Aktengesetz) холбогдох хэд хэдэн зохицуулалт бий бөгөөд нөлөө бүхий этгээд нь хувь хүн, хуулийн этгээд аль аль нь байж болно.

2 Герман

§117. Хохирлыг нөхөн төлөх үүрэг

§ 117.1. Компанид тогтоосон нөлөөллөө ашиглан, компани болон хувьцаа эзэмшигчид хохирол учруулж болзошгүй шийдвэр гаргахыг шаардаж, компанийн удирдлагад нөлөөлж буй этгээд нь компани болон хувьцаа эзэмшигчид учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

ДҮГНЭЛТ

ТӨК-ийн засаглалыг бэхжүүлэх гол хүчин зүйлсийн нэг бол ТУЗ нь хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэх чадамжтай

байх, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээдэг байх хууль зүйн тогтолцоог бүрдүүлэх явдал юм.

ТӨК-ийн ТУЗ-ийн бүрэн эрх: Эрх мэдлийн хуваарилалт

1. ТБОНӨТХ-ийн хүрээнд төрийн өмчийн удирдлагын эрхийг ТӨК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхээс бүрэн дүүрэн зааглаж чадаагүй. Төрийн өмчийн удирдлагын эрхийг ТӨК-ийн удирдлага, үйл ажиллагаанд оролцох эрхтэй хольсон байдал ажиглагддаг. Тодруулбал төрийн өмчийн удирдлагын эрх нь хувьцаа эзэмшигчийн эрхээр хязгаарлагдаагүй байна. Харин Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3-т Засгийн газар болон орон нутгийн эрх хэмжээ нь хувьцаа эзэмшигчийн эрхээс тусгаарлагдсан байх зарчмыг тусгаж өгсөн нь энэ тал дээр дэвшил авчирч болох юм.

2. Төрийн эрхийг хувьцаа эзэмшигчийн эрх гэж тодорхойлсноор Компанийн тухай хуулиар тодорхойлсон эрх мэдлийн хуваарилалтын дагуу хувьцаа эзэмшигч болох төр нь зөвхөн саналын эрхээр дамжуулан Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд тусгагдсан суурь асуудлуудыг шийдвэрлэхэд оролцох, харин ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд тусгагдсан компанийн удирдлага, менежментийг хариуцан ажиллаж, холбогдох шийдвэрийг бие даан гаргах боломж бүрдэх юм. Гэвч уг зарчмыг бүрэн хэрэгжүүлэхэд дараах асуудлуудыг зайлшгүй анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- ТБОНӨТХ хийгээд хуулийн төсөлд ТУЗ-ийн бүрэн эрхийг тодорхой хуульчлаагүй. Ялангуяа ТУЗ-ийн хамгийн чухал эрх болох компанийг стратегийн удирдлагаар хангах эрхийг тусгаагүй хэвээр байна. Одоо бодит байдал дээр ТӨК-ийг стратегийн удирдлагаар

хангах чиг үүргийг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байгууллага хэрэгжүүлж байна. Энэ нь ТӨК-д улс төрийн зүй бус нөлөөлөл ирэх нөхцөлийг бүрдүүлж байна.

- ТБОНӨТХ болон төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмын хүрээнд ТУЗ гүйцэтгэх захирлыг томилох бүрэн эрхээ бие даан хэрэгжүүлэх боломжгүй байна. Харин хуулийн төслийн 35.2 дугаар зүйлд гүйцэтгэх захирлыг томилох бүрэн эрхийг ТУЗ-д олгосон нь сайшаалтай байна.

- ТБОНӨТХ нь ТУЗ-д тодорхой эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг олгоогүй бол хуулийн төсөл ч мөн адил компанийн эд хөрөнгийг захиран зарцуулах ТУЗ-ийн бүрэн эрхийг баталгаажуулж чадахааргүй байна. Өөрөөр хэлбэл, үл хөдлөх хөрөнгө захиран зарцуулах бүрэн эрхийг Засгийн газарт олгож, үнэт цаас гаргах, зээл авахад хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс заавал авахаар тусгажээ.

3. ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.6 нь ТУЗ-ийн гишүүн хувьцаа эзэмшигчийн зүгээс өгсөн удирдамжийг баримтлан ажиллахыг үүрэг болгосон бөгөөд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмаар ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар удирдамж өгөх чиглэлүүдийг тогтоож өгсөн байдаг. Хуулийн төсөлд ТУЗ-ийн гишүүнд удирдамж өгөх явдал тусгагдаагүй ч дээрх журам хэвээр үйлчилж байгаа нөхцөлд ТУЗ-ийн гишүүнд удирдамж өгөх хууль зүйн боломж хэвээр үлдэнэ гэдгийг анхаарах нь зүйтэй.

4. Хувьцаа эзэмшигчийн эрхийг өргөжүүлэх

боломжийг Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 болон 62.1.16-д тусгасан байдаг. Үүнийг хуулийн төсөлд мөн адил тусгасан байна. Гэвч хувьцаа

эзэмшигчийн эрхийг хуулиар ийнхүү өргөжүүлэхдээ ямар ч тохиолдолд ТУЗ-ийн бүрэн эрхийг хөндөж болохгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

ТӨК-ийн ТУЗ-ийн хүлээх үүрэг ба хариуцлага

1. Монгол Улсын хувьд Компанийн тухай хууль, Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд тус тус ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүний итгэл даах үүргийн төрөл болох хянамгай байх, үнэнчээр ажиллах үүргийг тусгаж, зөрчилд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлж өгчээ. Гэвч хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төрийн эрх бүхий байгууллагаас зүгээс ТУЗ-ийн гишүүнээр хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг шүүхэд гаргахад идэвхгүй хандаж байна.
2. Бизнесийн шийдвэр гаргах дүрэм буюу ТУЗ нь мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах, ингэхдээ хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг эн

тэргүүнд тавьсан эсэхийг үнэлэх, хариуцлага хүлээлгэх эсхүл чөлөөлөх тухай зохицуулалт байхгүй байна. Энэ нь ТУЗ-ийн гишүүн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд бизнесийн шийдвэрийг бие даан гаргахад хүндрэл учруулж байна.

3. Төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтны зүгээс хуульд үл нийцэх удирдамж, чиглэлийг ТӨК-д өгөх, ашиг сонирхлын зөрчил бүхий шийдвэр гаргахыг тулгах зэргээр нөлөөлөх явдал түгээмэл байдаг. Гэтэл ийнхүү албан тушаал, улс төрийн давуу байдлаа ашиглан ТУЗ-ийн шийдвэрт нөлөөлөх боломжтой этгээдийг тодорхойлон хариуцлага хүлээлгэх зохицуулалт төсөлд тусгагдаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

- Төрийн өмчийн удирдлагын эрхийг хувьцаа эзэмшигчийн эрхээс зааглахын сацуу ТӨК-ийн үйл ажиллагаан дах төрийн оролцоог зөвхөн хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээний хүрээнд хязгаарлах шаардлагатай. Үүний тулд Төрийн өмчлөлийн бодлого (Ownership policy) батлах замаар “төр компанид хувьцааг эзэмшсэнийхээ хариуд гагцхүү хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээг эдлэх” зарчмыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх;
- Төр, түүнийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн зүгээс ТӨК-ийн ТУЗ-ийн хараат бус байдал, бие даасан байдлыг хүндэтгэж, ТУЗ-ийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхөөс зайлсхийх;
- ТӨК-ийн ТУЗ-ийн бие даасан байдлыг баталгаажуулахын тулд түүний бүрэн эрхийг маш тодорхой, ойлгомжтой байдлаар хуульчлах нь чухал. Иймд хуулийн төсөл тусгагдсан ТУЗ-ийн бүрэн эрхийг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд суурилан илүү тодорхой болгох нь зүйтэй. Ийнхүү ТУЗ-ийн бүрэн эрхийг хуульчлахад түүний хамгийн

чухал үндсэн эрх болох 1) Компанийг стратегийн удирдлагаар хангах 2) Гүйцэтгэх захирлыг томилох эрхийг зайлшгүй тусгах шаардлагатай;

- ТУЗ болон гүйцэтгэх захирлыг албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл хэр өргөн хүрээтэй байх тохиолдолд тэдгээр нь бүрэн эрхээ бие даан бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж хязгаарлагдана. Иймд хуулийн төсөлд тусгагдсан ТУЗ болон гүйцэтгэх захирлыг чөлөөлөх үндэслэлийг илүү нарийвчлан тодорхойлох;
- ТУЗ-д тодорхой хэмжээнд компанийн эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг олгох нь зүйтэй. Хуулийн төсөлд тусгагдсан үнэт цаас гаргах, зээл авах, ногдол ашгийн асуудлуудыг ТУЗ-ийн бүрэн эрхэд хамааруулах;
- Төрийн зүгээс аливаа төрлийн удирдамж, санал, заавар өгөх явдлыг бүр мөсөн халах нь зүйтэй. Хэрэв зайлшгүй тохиолдолд удирдамж өгөх үндэслэл, зорилгыг тодорхой болгож, агуулгад тодорхой шалгуур тавихын

зэрэгцээ, хувьцаа эзэмшигчийн эрх хэмжээтэй уялдуулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага аливаа асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчийн хурлаар дамжуулан ТУЗ-д уламжлах;

- Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг “хуульд заасан бусад”, “ТУЗ-ийн санал болгосон”, “компанийн дүрэмд заасан” гэх мэт зохицуулалтаар өргөжүүлэх нь зохисгүй тул хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг өргөжүүлэх агуулга бүхий ийм заалтуудыг хуулийн төслөөс хасах;
- Итгэл даах үүрэг ба тухайн үүргийн зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо нь холбогдох хууль болон журамд давхардсан байдалтай туссан нь ерөнхий хууль ба тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан тусгай хуулийн хооронд зөрчил үүсгэх, улмаар хууль хэрэглээнд төвөг учруулах эрсдэлтэй юм. ТУЗ-ийн гишүүний итгэл даах үүрэг түүнээс үүдэх хариуцлагын асуудал нь ТӨК болон хувийн хэвшлийн компанийн аль альд нийтлэг хамаарах учир ерөнхий хууль болох Компанийн тухай хуульд системчлэн оруулах нь илүү үр дүнтэй;
- Ихэнх улс оронд ТУЗ-ийн гишүүнийг шийдвэр

гаргахдаа судалгаатай хандсан, холбогдох бүх дүрэм журмыг баримталсан тохиолдолд тухайн шийдвэртэй холбоотойгоор хянамгай байх үүргийг зөрчсөн гэж үздэггүй. Тухайлбал, Индонез болон Герман Улсад бизнесийн шийдвэр гаргах дүрмийг тусгайлан хуульчилсан байдаг. Иймд үндэслэлтэй шийдвэр гаргасан ТУЗ-ийн гишүүнийг хамгаалах агуулга бүхий бизнесийн шийдвэр гаргах дүрмийг тодорхойлон Компанийн тухай хуульд тусгах;

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх журам, хариуцлагын хэмжээг тогтоох аргачлалыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд тодорхой тусгах;
- ТУЗ-ийн гишүүн биш боловч ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргах үйл явцад шууд болон шууд бус байдлаар нөлөөлөн улмаар өөрт ашигтай шийдвэр гаргуулах боломжтой нөлөө бүхий этгээдийг тодорхойлж, түүнд ТУЗ-ийн гишүүний нэгэн адил хариуцлага хүлээлгэх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалж

- G20/OECD (2015) Компанийн засаглалын зарчмууд, монгол хэл дээрх орчуулга;
- Б.Амарсанаа, 2012, Компанийн засаглал, компанийн эрх зүйн тулгамдсан асуудал, УБ;
- Г.Давааням, 2020, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, Соёмбо Принтинг;
- Г.Давааням, М.Түвшинжаргал, 2022, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөл: Олон Улсын Туршлага ба Монгол Улс Уул уурхайн салбарын жишээн дээр, Нээлттэй Нийгэм Форум;
- Г.Давааням, 2021, Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт, Соёмбо Принтинг;
- Г.Давааням, Ц. Золбоо, М.Түвшинжаргал, 2023, Төрийн болон орон нутгийн өмчит

компанийн тухай хуулийн төсөлд өгөх санал шүүмж, Нээлттэй Нийгэм Форум;

- Д.Байлхүү, 2014, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын засаглалын үнэлгээ;
- Д.Байлхүү, 2014, Төрийн өмчит эрчим хүчний компаниудын засаглалын үнэлгээ;
- Л.Анхбаяр, 2019, Хувьцаа эзэмшигч компанийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргахад тулгамдаж буй эрх зүйн зохицуулалт, Шүүх эрх мэдэл, №1 168;
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн танилцуулга-2020, Дэд ажлын хэсгийн тайлан;
- Ц.Одмоо, 2019, Төрийн өмчийг удирдах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал, 47 Эрх зүй №3 49.

Гадаад эх сурвалж

- A.Cahn & David C.Donald (2010) COMPARATIVE COMPANY LAW, Cambridge University Press;
- Dennis J.Block, Nancy E.Barton, Stephen A.Radin (1998) The Business Judgment Rule: Fiduciary Duties of Corporate Directors, Aspen Law and Business.
- Hasan Pulaşlı, Şirketler Hukuku Şerhi, (2017).
- Кьршат Гүдтүрк, Amerikan, Alman, İsvizre ve Түрк Hukukunda İşadami Karari İlkesi, İncüь Ёniversitesi Hukuk Fakültesi Dergisi Cilt:2, (2011)
- Luca Enriques, Henry Hansmann & Reinier Kraakman (2017) The Basic Governance Structure: The Interests of Shareholders as a Class, in THE ANATOMY OF CORPORATE LAW (R. Kraakman et al. eds. 3rd ed.);
- Lucian Bebchuk (2005) The Case for Increasing Shareholder Power, 118(3) Harv. Law Rev. 833;
- OECD (2010) Accountability and Transparency – A Guide for State Ownership, OECD Publishing;
- OECD (2013) Board of Directors of State-Owned Enterprises: An Overview of National Practices, OECD Publishing;
- OECD (2015) Board Practices and Financing for Latin American State Owned Enterprises, OECD Publishing;
- OECD (2015) Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises, OECD Publishing;
- OECD (2018) Professionalising BOARD of Directors of State-Owned Enterprises: Stocktaking National Practices OECD Publishing;
- OECD (2020) Organising The State Ownership Function-implementing the OECD Guidelines on Corporate Governance of State Owned Enterprises, OECD Publishing;
- OECD (2021) Owner and Governance of State-Owned Enterprises: A Compendium of National Practices, OECD Publishing;
- The World Bank (2014) Corporate Governance of State-Owned Enterprises: A Toolkit;
- Түрkiye ve Дьnya Kamu İşletmeleri (2015), Karşılaştırmalı Araştırma, İnceleme Raporu ve Siyasa Çnerileri.
- Цмер KORKUT (2010) Anonim Şirketlerde Fili Yünetim Kurulu Ёyeliđi, Zukurova Ёniversitesi Dergisi;
- 江頭憲治郎『株式会社法』（有斐閣 第7版 2017年）；

Эрх зүйн эх сурвалж

- 6102 sayılı Түрк Ticaret Kanunu (2012);
- Model Business Corporation Act;
- The Establishment, Management, Supervision and Dissolution of State Owned Enterprises. Government Regulation No. 23/2022;
- Ministry of Trade and Industry, The Government Ownership Policy, Oslo (2008);
- Government offices of Sweden, State Ownership Policy and principles for state-owned enterprises, Stockholm (2020);
- Act on state company ownership and ownership control, 21.12.2007/n.1368;
- Засгийн газрын тогтоол 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралт, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”;
- Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол №266, Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай, 2006 он [https://www.legalinfo.mn/law/details/4130];
- Монгол Улсын Засгийн Газрын Тогтоолын Хавсралт № 20, Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам, 2016 он [https://www.legalinfo.mn/annex/details/7415?lawid=12142].
- Монгол Улсын Их Хурал, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2020.08.28 №24 тогтоол;
- Монгол Улсын Их Хурал, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, 2021.01.22 №12 тогтоол;
- Монгол Улсын Компанийн тухай хууль, 2011 он;
- Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 1996 он.